



**Байгаль орчны үнэлгээний мэргэжлийн
байгууллага “ЭРТЭЧ НАРАН” ХХК**

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНХОНГОР СУМЫН
ТАВАНТОЛГОЙ-БАНУУННАРАНГИЙН ЧИГЛЭЛИЙН
32 КМ АВТОЗАМЫН ТӨГСГӨЛӨӨС “ЦАГААН ДЭЛ
УУЛ” ХИЛИЙН БООМТ ХҮРТЭЛХ 270 КМ ТУСГАЙ
ЗОРИУЛАЛТЫН АВТОЗАМ БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2026 ОНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Регистрийн дугаар: **6215912**

Улаанбаатар – 2026 он

ГАРЧИГ

ОРШИЛ

1.	ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	1
1.1	Ерөнхий зүйл.....	1
1.1.1	Төсөл хэрэгжүүлэгчийн бүртгэлийн мэдээлэл.....	1
1.1.2	Үндсэн үйл ажиллагаа ба төрийн бодлого	1
1.1.3	Компаний танилцуулга ба мэдээллийн ил тод байдал	1
1.2	Зам барилгын бүтээн байгуулалтын 2026 оны төлөвлөлт	2
1.2.1	Төслийн үндсэн төлөвлөлт ба нөлөөллийн тодорхойлолт.....	2
1.2.2	Төлөвлөлтийн багц болон зам барилгын материал ашиглалт	3
1.2.3	Төлөвлөгөөт ажлын хүрээн хийх гарц, гарам, ус нэвтрүүлэх хоолой	5
1.3	Завсрын үйл ажиллагаа ба завсрын бүтээгдэхүүн	5
1.3.1	Машин, механизм, тоног төхөөрөмжийн ашиглалт	5
1.3.2	Түр кемп байрлуулах, ашиглах үйл ажиллагааны тодорхойлолт	6
1.3.3	Төслийн хэрэгцээний ус ба ус хангамж	10
1.3.4	Зэрлэг амьтдын гарц гарам	11
1.4	Завсрын үйл ажиллагаа ба завсрын бүтээгдэхүүн	12
1.4.1	Оператор компаниудын зохион байгуулалт	12
1.4.2	Төслийн хог хаягдал, хог хаягдлын тодорхойлолт.....	13
2.	ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ	14
2.1	Төсөл хэрэгжих талбайн байршил, физик газарзүйн нөхцөл.....	14
2.2	Уур амьсгал, цаг уур	15
2.3	Гадаргын ус	16
2.3.1	Усны сав газар	16
2.3.2	Төслийн бүс нутгийн гадаргын ус	16
2.4	Газрын доорх ус	17
2.5	Хөрсөн бүрхэвч.....	18
2.6	Нөмрөг ургамал	19
2.7	Ойн сан	20
2.8	Амьтны аймаг.....	20
3.	ТӨСЛИЙН СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	23
3.1	Төслийг хэрэгжүүлэх үе шат	23
3.2	Төслийн сөрөг нөлөөллийн тодорхойлолт	23

3.2.1	Замын ерөнхий төлөвлөлтөд тавигдах шаардлага.....	23
3.2.2	Төслийн хүрээнд үүсэх нөлөөллийн тодорхойлолт.....	25
4.	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	26
4.1	Ерөнхий зүйл.....	26
4.1.1	БОМТ-ний гол зорилго.....	26
4.1.2	Байгаль орчны менежментийн 2026 оны төлөвлөгөөний нийт зардал.....	26
4.2	Байгаль орчны менежментийн гол төлөвлөлтүүд	27
4.2.1	Сөрөг нөлөөг бууруулах төлөвлөгөө	27
4.2.2	Биологийн олон янз байдлыг хамгаалах арга хэмжээний төлөвлөлт	30
4.2.3	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	34
4.2.4	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	34
4.2.5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	35
4.2.6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	38
4.2.7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	40
4.2.8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	42
	Уур амьсгал, агаарын чанарын үзүүлэлтүүд.....	42
	Ус ашиглалтад тавих хяналт	42
	Газрын гадарга ба хөрсний хяналтын үзүүлэлтүүд.....	42
4.2.9	Биологийн олон янз байдлын хяналт, мониторинг.....	43
4.2.10	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд зааснаар:.....	44
4.2.11	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	43
4.2.12	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах	45

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭЭС ХҮЛЭЭХ ҮР ДҮН
АШИГЛАСАН МАТЕРИАЛ, МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР
ХАВСРАЛТУУД

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн замын бүтээн байгуулалтын ажлын хэмжээ ба нөөцийн хуваарилалт ..3	
Хүснэгт 2. Багц 3 болон 4 дээр төлөвлөсөн ус нэвтрүүлэх хоолойн байршлууд.....5	
Хүснэгт 3. Бүтээн байгуулалтын ажлын зохион байгуулалт, нөөцийн хуваарилалт5	
Хүснэгт 4. Түр кемп байрлуулах, ашиглах үйл ажиллагааны нөлөөллийн тодорхойлолт6	
Хүснэгт 5. Туслан гүйцэтгэгч-1 -ийн ашиглахаар төлөвлөж буй түр кемпийн байрлал.....6	
Хүснэгт 6. Туслан гүйцэтгэгч-2-ийн ашиглахаар төлөвлөж буй түр кемпийн байрлал.....6	
Хүснэгт 7. Туслан гүйцэтгэгч-3-ийн ашиглахаар төлөвлөж буй түр кемпийн байрлал.....7	
Хүснэгт 8. Туслан гүйцэтгэгч-4-ийн ашиглахаар төлөвлөж буй түр кемпийн байрлал.....7	
Хүснэгт 9. Туслан гүйцэтгэгч-5-ийн ашиглахаар төлөвлөж буй түр кемпийн байрлал.....7	
Хүснэгт 10. Туслан гүйцэтгэгч-6-ийн ашиглахаар төлөвлөж буй түр кемпийн байрлал.....8	
Хүснэгт 11. Зөвлөх компанийн ашиглахаар төлөвлөж буй түр кемпийн байрлал.....8	
Хүснэгт 12. Ерөнхий гүйцэтгэгч-ийн ашиглахаар төлөвлөж буй түр кемпийн байрлал8	
Хүснэгт 13. Шинээр худаг гаргах төлөвлөлтийн нөлөөллийн тодорхойлолт 11	
Хүснэгт 14. Зам барилгын бүтээн байгуулалтад ашиглах усны хэрэглээ 11	
Хүснэгт 15. Бүтээн байгуулалтын үеийн унд ахуйн усны хэрэглээ 11	
Хүснэгт 16. Мал, зэрлэг ан амьтны гарам. Багц 3 11	
Хүснэгт 17. Ахуйн хог хаягдлын хэмжээ.....13	
Хүснэгт 18. Төслийн бүс нутгийн усны сав газрын тодорхойлолт.....16	
Хүснэгт 19. Хөхтөн амьтдын хамгаалагдсан байдал.....20	
Хүснэгт 20. Төслийн бүс нутагт тархсан шувуудын хамгаалагдсан байдал.....22	
Хүснэгт 21. Төслийн замын ерөнхий төлөвлөлтөд тавигдах шаардлага ба тодорхойлолт..23	
Хүснэгт 22. БОМТ-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх нийт зардлын бүтэц, хуваарилалт26	
Хүснэгт 23. Монгол мөнххарганы хамгааллын бодлогын суурь30	
Хүснэгт 24. Хамгааллын арга хэмжээний бодлого.....35	
Хүснэгт 25. Трассын дагуух зурвас газарт бүртгэгдсэн түүхийн дурсгалт зүйлүүд.....36	
Хүснэгт 26. Түүхийн дурсгалт зүйлүүдийг хамгаалах арга хэмжээний зардлууд37	
Хүснэгт 27. Галын буланд заавал байршуулах иж бүрдлүүдийн хэсгүүд.....38	
Хүснэгт 28. Осол эрсдэлээс хамгаалах арга хэмжээний зардал.....39	
Хүснэгт 29. Хог хаягдлын менежментийг зохион байгуулах арга хэмжээний зардал41	
Хүснэгт 30. Экологийн хяналт, мониторингийн хамрах хүрээ43	
Хүснэгт 31. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал46	
Хүснэгт 32. Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөлт44	
Хүснэгт 33. Төлөвлөгөөний хэрэгжилтийг оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө45	

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. “Ундрах говь” ХХК-ий бүтэц, зохион байгуулалт	1
Зураг 2. Төлөвлөж буй трассын замын бүтээн байгуулалтын багцын төлөвлөлт	2
Зураг 3. Тусгай зориулалтын замын 155.2 км хэсгийн бүтээн байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, 2026-2027	3
Зураг 4. Бүтээн байгуулалтад 2026-027 онд ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмалын карьеруудын байршил	4
Зураг 5. 2026-2027 онд ашиглаах кемпүүдийн байршил	9
Зураг 6. Трассын дагуух гар болон шинээр гаргах худгийн байршлууд	10
Зураг 7. Төлөвлөж буй трассын дагуух газрын гадаргын байдал	14
Зураг 8. Монгол орны гадаргын усны сүлжээн дэх төслийн трассын байршил	17
Зураг 9. Газрын доорх усны тэжээгдлийн муж дахь төслийн трассын бүс нутаг	18
Зураг 10. <i>Equus hemionus</i> – Хулан адуу	21
Зураг 11. <i>Gazella subgutturosa</i> – Хар сүүлтий	22
Зураг 12. Төслийн хөгжлийн үе шатууд, ТЭЗҮ дэх төлөвлөлтөөр	23
Зураг 13. Оператор компаниудын кемпийн газар ашиглах төлөвлөлтийн загвар	27
Зураг 14. Монгол мөнххаргана- <i>Ammoptanthus mongolicus</i>	30
Зураг 15. Төлөвлөж буй трасс дээр байгуулах зэрлэг амьтны гарцын байршлууд	32
Зураг 16. Ангилсан хог хаягдал түр хадгалах савны сонголт	40

ОРШИЛ

Төлөвлөж буй авто зам нь Тавантолгой-Барууннарангийн авто замын төгсгөлөөс эхний 6 км гаруй хэсэгт намхан толгодын дундуур гарч, Цавчирын голын сайрыг хөндлөн гарч, Их уул, Чандмань болон Хан уулын урдуур хөндий уруудаж, Балгасын Улаан нуураас 5.3 км-ийн зайтайгаар Нарийн голын сайрыг хөндлөн гарч, Ханхонгор сумын Жаргалант бригадын хойгуур 1.5 км, Хүрмэн сумын зүүн урдуур 20 км-ийн зайтайгаар Буурал хяр уулын хормойгоор дайран урд зүгийг чиглэн хөндий өгсөж, Эрдэнэбулагийн бүлэг нүүрсний уурхайн зүүн талаар өнгөрнө. Эрдэнэбулагийн бүлэг нүүрсний уурхайгаас хөндий дагаж өгсөн, Их эрээн уулын баруун талаар гарч, Цээлийн хөндий дагаж өгсөн, Баруун цохионы нурууг давж, хөндий уруудаж, тэгш талаар явсаар Хөндсийн уулын хавцлаар сайрын зүүн талын тавцангаар гарна. Хавцлаас зүүн урд чиглэн уул толгодын дундуур гарч, Хүрзэн уулыг даван намхан толгодын дундуур гарч, Хужирт хүрэн уулын баруун талаар гарч Цагаан дэл уулын хилийн боомтод хүрнэ.

Энэ төсөл нь Тавантолгойн нүүрсний бүлэг орд газраас “Цагаандэл уул” хилийн боомт хүртэл хүнд даацын авто зам барьж байгуулахдаа трассын дагуу шилэн кабель татах, гэрэлтүүлэг хийх, камержуулах, нүүрс тээврийн хөдөлгөөн зохион байгуулалтын төвүүд болон тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний төв байгуулах цахилгаан татах зэрэг асуудлыг цогцоор нь шийдвэрлэнэ. Төслийг Монгол Улсын Концессын тухай хуулийн хүрээнд авто замыг барьж 20 жилийн хугацаанд ашиглан хөрөнгө оруулалтын зардлаа нөхсөний дараа Монгол Улсын Засгийн газарт үнэ төлбөргүй шилжүүлнэ. Тиймээс төлөвлөж буй авто зам нь эхний 20 жилдээ төлбөртэй зам байх бөгөөд тухайн бүс нутагт уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж, нүүрсний экспортын тээвэр гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжүүд төлбөр төлөгч нь байна. Төлөвлөж буй авто зам нь Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 317 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д орсон.

Төслийн хэрэгжилт 2019 оноос Коюид-19 цар тахал, орон нутгийн иргэдийн эсэргүүцэл зэрэг олон бодит шалтгааны улмаас хойшилсон 2025 онд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тодотголыг батлуулсан. Тус төсөл 2025 онд мөн үйл ажиллагаа явуулаагүй тул 108.5 сая төгрөгийн төсөв бүхий тус менежментийн төлөвлөгөөг 2026 онд хэрэгжүүлэхээр хойшлуулсан болно.

Байгаль орчны менежментийн 2026 оны төлөвлөгөө нь тооцсон зардлын 12.3хувь буюу 13.3 сая төгрөг нь орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулна.

“ЭРТЭЧ НАРАН” ХХК

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Ерөнхий зүйл

1.1.1 Төсөл хэрэгжүүлэгчийн бүртгэлийн мэдээлэл

Төслийн нэр:	Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Баруун нарангийн чиглэлийн 32 км автозамын төгсгөлөөс “Цагаан дэл уул” хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын автозам
Төсөл хэрэгжүүлэгч:	“Ундрах говь” ХХК Регистрийн дугаар 6215912 Улсын бүртгэлийн дугаар 9011692052
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Хан-Уул дүүрэг, 26-р хороо, Энканто таун.13311, Их Монгол улсын шудамж,305-71 Утас: 976-8811-8769, 9914-8019 Имэйл: info@undrakhgobi.mn
Төсөл хэрэгжих газрын байрлал:	Өмнөговь аймаг, Ханхонгор-Хүрмэн-Номгон сумд,

1.1.2 Үндсэн үйл ажиллагаа ба төрийн бодлого


Тавантолгойн нүүрсний ордын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, холбогдох дэд бүтцийг барьж байгуулах зорилгоор дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар-т даалгасан Монгол Улсын Их Хурлын 2018 оны “Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний хүрээнд Тавантолгой-Барууннаран чиглэлийн авто замын төгсгөлөөс Цагаандэл уул чиглэлийн тусгай зориулалтын авто замыг барьж байгуулах зорилгыг Засгийн Газар 2018 онд тодорхойлсон.

1.1.3 Компаний танилцуулга ба мэдээллийн ил тод байдал

“Ундрах говь” ХХК 2017 онд байгуулагдсан. Удирдах дээд байгууллага Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ бөгөөд нийт 20 ажилтантай, ажилтнуудын 60 орчим хувь нь инженер техникийн мэргэжилтэй.

Одоогийн үндсэн үйл ажиллагаа нь төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд чиглэж байгаа бөгөөд Тавантолгой – Цагаан дэл уулын боомт чиглэлийн авто замын судалгааны ажлыг 2018 оноос эхлүүлсэн байна.

Зураг 1. “Ундрах говь” ХХК-ий бүтэц, зохион байгуулалт




Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Баруун нарангийн чиглэлийн 32 км автозамын төгсгөлөөс “Цагаан дэл уул” хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын автозамын төслийн байгаль орчны менежментийн 2026 оны төлөвлөгөө

1.2 Зам барилгын бүтээн байгуулалтын 2026 оны төлөвлөлт


1.2.1 Төслийн үндсэн төлөвлөлт ба нөлөөллийн тодорхойлолт

“Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс “Цагаан дэл уул” хилийн боомт хүртэлх 270 км авто зам төсөл” нь Өмнөговь аймгийн Ханхонгор, Номгон, Хүрмэн сумуудыг нутаг дэвсгэрээр дайран өнгөрнө.



Зураг 2. Төлөвлөж буй трассын замын бүтээн байгуулалтын багцын төлөвлөлт

Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Баруун нарангийн чиглэлийн 32 км автозамын төгсгөлөөс “Цагаан дэл уул” хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын автозамын төслийн байгаль орчны менежментийн 2026 оны төлөвлөгөө



Зураг 4. Бүтээн байгуулалтад 2026-027 онд ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмалын карьеруудын байршил

Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Баруун нарангийн чиглэлийн 32 км автозамын төгсгөлөөс “Цагаан дэл уул” хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын автозамын төслийн байгаль орчны менежментийн 2026 оны төлөвлөгөө

1.2.3 Төлөвлөгөөт ажлын хүрэн хийх гарц, гарам, ус нэвтрүүлэх хоолой

Нийт 531 цэг дээр гадаргын усны тохиргоо хийх ба энэ нь 1.97 км тутамд урсац нэвтрүүлнэ. Үүнд:

- **Гүүр.** Трассын Км44+840 байрлалд 18м-ийн алгасал бүхий гүүр хийнэ.
- **Хоолой.** Трассын дагууд нийтдээ 464 цэгт төмөр бетон хоолой төлөвлөгдсөнөөс 1.0x1 хэмжээний диаметртай дугуй хоолой 138 байх бол, 1.0x1.0x1-ээс 4.0x4.0x2 хүртэл хэмжээтэй дөрвөлжин хоолой 328 байна.
- **Ус давуулах далан.** Үерийн ус өнгөрүүлэхээр 66 байрлалд давуулах далан хийнэ.

2026 онд ус нэвтрүүлэх төмөр бетон хоолой багц 3 дээр 8, багц 4 дээр 11 байна. Мөн 2026-2027 онд бүтээн байгуулах 155.2 км зам дээр нэг түвшний гарц 11, малын гарам 20 байхаар төлөвлөсөн бий.

Хүснэгт 2. Багц 3 болон 4 дээр төлөвлөсөн ус нэвтрүүлэх хоолойн байршил

БАГЦ - 3					БАГЦ - 4				
№	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тайлбар	№	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тайлбар
9	Төмөрбетон хоолойн ажил				9	Төмөрбетон хоолойн ажил			
9.1	Дугуй хоолой D1000	ш	19.00		9.1	Дугуй хоолой D1000	ш	96.00	
9.2	Дөрвөлжин хоолой 1.0x1.0x1	ш	49.00		9.2	Дөрвөлжин хоолой 1.0x1.0x1	ш	37.00	
9.3	Дөрвөлжин хоолой 1.0x1.0x2	ш	19.00		9.3	Дөрвөлжин хоолой 1.0x1.0x2	ш	27.00	
9.4	Дөрвөлжин хоолой 1.0x1.0x3	ш	2.00		9.4	Дөрвөлжин хоолой 1.0x1.0x3	ш	9.00	
9.5	Дөрвөлжин хоолой 1.0x2.0x2	ш	5.00		9.5	Дөрвөлжин хоолой 1.0x2.0x2	ш	1.00	
9.6	Дөрвөлжин хоолой 2.0x2.0x1	ш	6.00		9.6	Дөрвөлжин хоолой 2.0x2.0x1	ш	10.00	
9.7	Дөрвөлжин хоолой 2.0x2.0x2	ш	4.00		9.7	Дөрвөлжин хоолой 2.0x2.0x2	ш	5.00	
9.8	Дөрвөлжин хоолой 2.0x2.5x1	ш	4.00		9.8	Дөрвөлжин хоолой 2.0x2.5x1	ш	1.00	
9.8	Дөрвөлжин хоолой 2.0x2.5x2	ш	4.00		9.9	Дөрвөлжин хоолой 2.0x2.5x2	ш	3.00	
			108.00		9.10	Дөрвөлжин хоолой 2.0x2.5x3	ш	1.00	
					9.11	Дөрвөлжин хоолой 4.0x4.0x2	ш	1.00	

Тодруулбал дунджаар 14 км тутамд нэг маягийн гарц, 7.7 км тутамд нэг малын гарц хийгдэнэ гэсэн үг юм.

1.3 Завсрын үйл ажиллагаа ба завсрын бүтээгдэхүүн

1.3.1 Машин, механизм, тоног төхөөрөмжийн ашиглалт

Тусгай зориулалттай автозамын бүтээн байгуулалт дээр нийт 820 ажилчин, 35 нэр төрлийн 547 ширхэг техник, тоног төхөөрөмжийг ашиглана.

Хүснэгт 3. Бүтээн байгуулалтын ажлын зохион байгуулалт, нөөцийн хуваарилалт

№	Ажлын багцлал	Ажлын хэмжээ, куб м.	Техникийн ажилчид	Ажиллах техник
1	Багц-I	403,810.2	170	115
2	Багц-II	694,457.8	170	115
3	Багц-II	479,696.4	310	180
4	Багц-II	781,522.4	170	137
	Нийт	2,359,486.8	820	547

Эдгээрээс 2026-2027 онд газар шорооны ажлын 53.46 хувь нь хийгдэх бөгөөд техникийн болон хүний нөөцийн 57.9-58.6 хувийг ашиглана.. Жилд дунджаар 210 хоног ажиллах болно. Жилийн хугацаанд 2,268-2,709 тн түлш хэрэглэнэ.

1.3.2 Түр кемп байрлуулах, ашиглах үйл ажиллагааны тодорхойлолт

Төсөл хэрэгжүүлэгч зам барилгын бүтээн байгуулалтыг хийхийн тулд зам барилга барьж байгуулах тусгай зөвшөөрөл 8 компанитай гүйцэтгэлийн гэрээ хийж бүтээн байгуулалтын үед тэдгээрийн түр кемпийг байршуулах 19 газар байршлын зөвшөөрлийг авсан. Энэ нь төлөвлөж буй 270 км замын хувьд оператор компанид дунджаар 33.75 км зам ногдож, зам барилгад ашиглах 2 карьерын дунд нэг түр кемп байрлана гэсэн үг юм. Бүтээн байгуулалтын үеийн түр кемпэд 0.08-аас 6.68 хүртэл га талбайг тус бүр 3 гурван сарын хугацаатай олгосон нь төслийн амьдралын мөчлөгт 1.25 хувийг эзэлнэ.

Хүснэгт 4. Түр кемп байрлуулах, ашиглах үйл ажиллагааны нөлөөллийн тодорхойлолт

№	Төслийн төлөвлөлт	Нөлөөллийн тодорхойлолт
1	Гүйцэтгэлийн 4 компани бүтээн байгуулалтын үед түр кемпийг 19 газар байршуулах зөвшөөрөлтэй	Нэгж компани дунджаар 4-5 түр кемп ашиглана. Нөлөөллийг тайлангийн ... бүлэгт дэлгэрэнгүй үнэлнэ.
2	Нэгж түр кемпийг 3 сараар ашиглана.	Гүйцэтгэлийн нэгж компани 6 сараар ажиллах ба энэ төслийн амьдралын мөчлөгт 3.0 хувийг эзэлнэ.
3	Түр кемп ашиглалтын үед орон нутгийн захиргаанаас хяналт тавина.	Хууль, тогтоомжоор заасан хяналтын механизм ажиллаж, хуулийн хэрэгжилт хангуулна.
4	Түр ашигласан карьеруудыг хэлбэршүүлэн нөхөн сэргээнэ.	Бүтээн байгуулалтын үед хяналт мониторинг хийх БОМ-ын 5 жилийн төлөвлөгөөнд тусгасан бий.

Авто замын барилга угсралтын ажлыг зохион байгуулахад 19 байршилд туслах кемп байгуулах бөгөөд эдгээр кемпүүдэд цемент бетоны үйлдвэр, чулуу бутлуур, цементээр бэхжүүлсэн суурийн материал бэлтгэх үйлдвэрийг барьж байгуулан хариуцсан хэсгийн ажлыг дуусгаж, дараагийн “б” цэгийн байршилд шилжүүлэн зөөвөрлөж ашиглахаар төлөвлөж байна. Төслийн замын хэсэг тус бүрд үндсэн ба туслах кемпүүд зохион байгуулан ажиллуулна.

Хүснэгт 5. Туслах гүйцэтгэгч-1-ийн ашиглахаар төлөвлөж буй түр кемпийн байрлал

Кемпийн дугаар	Х	Ү	Байрлал /замын пикетээр/	Талбай / га /
Кемп-1	437220.644	4763074.911	Багц-3. 4+560 баруун	1.33
	437338.554	4763066.211		
	437308.775	4762953.07		
	437197.145	4762958.076		
Кемп-2	435055.274	4756965.412	Багц-3. 11+160 баруун	0.87
	435136.925	4756917.746		
	435095.852	4756836.725		
	435013.89	4756878.275		
Кемп-3	432252.582	4751700.844	Багц-3. 17+180 баруун	0.72
	432337.597	4751673.583		
	432299.885	4751597.543		
	432222.359	4751620.226		

Хүснэгт 6. Туслах гүйцэтгэгч-2-ийн ашиглахаар төлөвлөж буй түр кемпийн байрлал

Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Баруун нарангийн чиглэлийн 32 км автозамын төгсгөлөөс “Цагаан дэл уул” хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын автозамын төслийн байгаль орчны менежментийн 2026 оны төлөвлөгөө

Кемпийн дугаар	Х	Ү	Байрлал /замын пикетээр/	Талбай / га /
Кемп-1.	430161.000	4746457.000	Багц-3. 23+060 зүүн	0.08
	430188.000	4746465.000		
	430197.000	4746438.000		
	430168.000	4746429.000		
Кемп-2.	428539.000	4741183.000	Багц-3. 28+560 баруун	0.99
	428636.000	4741180.000		
	428646.000	4741080.000		
	428552.000	4741075.000		
Кемп-3.	428056.000	4734606.000	Багц-3. 35+200 зүүн	0.26
	428112.000	4734616.000		
	428128.000	4734574.000		
	428072.000	4734561.000		

Хүснэгт 7. Туслан гүйцэтгэгч-3-ийн ашиглахаар төлөвлөж буй түр кемпийн байрлал

Кемпийн дугаар	Х	Ү	Байрлал /замын пикетээр/	Талбай / га /
Кемп-1.	428741.301	4723511.496	Багц-3. 46+700 зүүн	3.27
	428889.443	4723562.027		
	428999.840	4723406.586		
	428837.470	4723330.138		
Кемп-2.	429599.478	4715756.955	Багц-3. 55+000 баруун	4.99
	429846.293	4715773.265		
	429985.857	4715547.330		
	429786.436	4715547.330		

Хүснэгт 8. Туслан гүйцэтгэгч-4-ийн ашиглахаар төлөвлөж буй түр кемпийн байрлал

Кемпийн дугаар	Х	Ү	Байрлал /замын пикетээр/	Талбай / га /
Кемп-1.	432670.783	4710275.937	Багц-3. 61+060 баруун	2.59
	432763.558	4710294.539		
	432772.631	4710085.187		
	432613.928	4710065.940		
Кемп-2.	428691.242	4702323.876	Багц-3. 70+800 баруун	6.54
	428896.626	4702182.978		
	428684.226	4701933.237		
	428556.990	4701933.237		

Хүснэгт 9. Туслан гүйцэтгэгч-5-ийн ашиглахаар төлөвлөж буй түр кемпийн байрлал

Кемпийн дугаар	Х	Ү	Байрлал /замын пикетээр/	Талбай / га /
Кемп-1.	431929.107	4687919.228	Багц-3. 86+680 баруун	1.99
	431992.777	4687996.339		
	432147.000	4687869.000		

Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Баруун нарангийн чиглэлийн 32 км автозамын төгсгөлөөс “Цагаан дэл уул” хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын автозамын төслийн байгаль орчны менежментийн 2026 оны төлөвлөгөө

	432083.330	4687791.889		
--	------------	-------------	--	--

Хүснэгт 10. Туслан гүйцэтгэгч-б-ийн ашиглахаар төлөвлөж буй түр кемпийн байрлал

Кемпийн дугаар	Х	Ү	Байрлал /замын пикетээр/	Талбай / га /
Кемп-1.	434339.909	4679937.260	Багц -4. 0+100 баруун	3.95
	434458.706	4679954.207		
	434319.293	4679746.132		
	434020.293	4679722.293		
Кемп-2.	434140.272	4675270.726	Багц -4. 6+620 баруун	1.57
	434303.000	4675387.000		
	434361.137	4675387.000		
	434198.409	4675189.362		
Кемп-3.	435398.900	4669641.444	Багц -4. 15+660 баруун	2
	435498.122	4669628.994		
	435473.222	4669430.550		
	435374.000	4669443.000		


Хүснэгт 11. Зөвлөх компанийн ашиглахаар төлөвлөж буй түр кемпийн байрлал

Кемпийн дугаар	Х	Ү	Байрлал /замын пикетээр/	Талбай / га /
Кемп-1.	428130.056	4734032.847	Багц-3. 35+800	1
	428230.056	4734032.847		
	428230.785	4733932.849		
	428130.056	4733932.849		
Кемп-2.	437680.448	4665595.197	Багц-4. 18+800	1
	437780.448	4665595.197		
	437781.177	4665495.200		

Хүснэгт 12. Ерөнхий гүйцэтгэгч-ийн ашиглахаар төлөвлөж буй түр кемпийн байрлал

Кемпийн дугаар	Х	Ү		Талбай / га /
Кемп-1.	436916.955	4763774.324	Багц-3. 4+000 баруун	6.68
	437136.830	4763731.400		
	437083.542	4763462.436		
	436827.644	4763507.710		
Кемп-2.	428275.358	4735550.602	Багц-3. 34+300 зүүн	3.96
	428489.128	4735550.602		
	428489.128	4735370.729		
	428275.358	4735359.495		
Кемп-3.	428876.059	4702919.013	Багц-3. 70+000 баруун	2.27
	428989.620	4702845.916		
	428881.903	4702715.894		
	428766.113	4702814.060		


Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Баруун нарангийн чиглэлийн 32 км автозамын төгсгөлөөс “Цагаан дэл уул” хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын автозамын төслийн байгаль орчны менежментийн 2026 оны төлөвлөгөө



Зураг 5. 2026-2027 онд ашиглах кемпүүдийн байршил

1.3.3 Төслийн хэрэгцээний ус ба ус хангамж

Алтайн өвөр говийн сав захиргааны зөвшөөрлийн хүрээнд төслийн трассын дагууд 8 цэг дээр гүний худаг гаргах ба шинээр худаг гаргах зөвшөөрлийн байршлууд нь трассын өмнөд хэсгээр байршилтай.



Зураг 6. Трассын дагуух гар болон шинээр гаргах худагийн байршлууд

Хүснэгт 13. Шинээр худаг гаргах төлөвлөлтийн нөлөөллийн тодорхойлолт

№	Төлөвлөлт	Нөлөөллийн тодорхойлолт
1	Шинээр гаргах худгийн байршлыг гидрогеологийн болон газар доорх усны ордуудын судалгаанд үндэслэн сонгосон.	Сонгосон цэгүүдэд төслийн бүтээн байгуулалтын хэрэгцээг хангах боломжит усны нөөц бий гэж үзсэн.
2	Шинээр гаргах худгууд нь трассын өмнөд хэсгээр хоорондоо дунджаар 17.5 км зайтай байршилтай.	Номгон болон Хүрмэн сумдын нутагт тарассын дагууд усны найдвартай эх үүсвэртэй болно.
3	Шинээр гаргах худгуудын 6 –г нь бүтээн байгуулалтын дараа орон нутагт хүлээлгэн өгнө.	Номгон болон Хүрмэн сумдын нутагт алсын бэлчээрт ус хангамж сайжирна.

Төслийн трассын бүтээн байгуулалтаар технологийн хэрэгцээнд 133.3 мянган шоо метр, унд ахуйн хэрэгцээнд 6.05 мянган шоо метр усыг хэрэглэнэ.

Хүснэгт 14. Зам барилгын бүтээн байгуулалтад ашиглах усны хэрэглээ

№	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Ус хэрэглээ, норм, м ³	Ус хэрэглээ, м ³
1	Зөөврийн шороогоор далан байгуулах	м3	608,330	0.08	48,666.4
2	Хөлдөлтөөс хамгаалах үе байгуулах	м3	535,400	0.08	42,832
3	Суурийн доод үе байгуулах	м3	418,000	0.10	41,800
	Нийт		1,561,730		133,298.4

Хүснэгт 15. Бүтээн байгуулалтын үеийн унд ахуйн усны хэрэглээ

Ажиллах хүч	2026он		Нийт
	Гуравдугаар төслийн удирдлагын хэсэг	Дөрөвдүгээр төслийн удирдлагын хэсэг	
	92км	63.2км	
Нийт ажилчдын тоо	340	300	640
Ундны ахуйн зориулалтаар хоногт 1 хүн ашиглах усны хэмжээ l	45 литр		
1хоногт зарцуулах ус, л/хоног	15,300	13,500	28,800
Сард хэрэглэх ус, м3	459	405	864
Нэг жилд буюу зам барилгын ажлын хугацаанд / 7 сар буюу 2024 онд /	3,213	2,835	6,048

1.3.4 Зэрлэг амьтдын гарц гарам

Нийт 270 км урт трассын дагууд зэрлэг амьтдын нутаг сэлгэхэд зориулан нийт 20 гаруй гарц төлөвлөж байгаагаас 16 нь 3 дугаар багц, 4 нь 4 дүгээр багцын ажлын хүрээнд шийдэгдэнэ.

Хүснэгт 16. Мал, зэрлэг ан амьтны гарам. Багц 3

Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Баруун нарангийн чиглэлийн 32 км автозамын төгсгөлөөс “Цагаан дэл уул” хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын автозамын төслийн байгаль орчны менежментийн 2026 оны төлөвлөгөө

№	Байрлал, КМ		Урт, м
	Эхлэл	Төгсгөл	
1	0+570	0+620	25
2	2+010	2+060	25
3	3+450	3+500	25
4	17+750	17+800	25
5	24+700	24+750	25
6	31+235	31+285	25
7	33+960	34+010	25
8	43+420	43+470	25
9	49+310	49+360	25
10	63+690	63+740	25
11	65+995	66+045	25
12	67+520	67+570	25
13	71+850	71+900	25
14	77+800	77+850	25
15	81+150	81+200	25
16	90+640	90+690	25
17	1+055	1+105	25
18	3+450	3+500	25
19	10+650	10+700	25
20	18+015	18+065	25

1.4 Завсрын үйл ажиллагаа ба завсрын бүтээгдэхүүн

1.4.1 Оператор компаниудын зохион байгуулалт

Төсөл хэрэгжүүлэгч 2026 онд дараах оператор компаниудтай гэрээ хийснээр 155 км урт трассад зам барилгын бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Хан хүдэр майнинг ХХК
- Хөгжлийн тод зам ХХК
- Өргөн ээв ХХК зэрэг болно.

Тиймээс төслийн БОННУ-нд тусгасан байгаль орчны сөрөг нөлөөллийг хянах, бууруулах, хамгаалах зэрэг зэрэг үүргийг оператор компаниудад шилжүүлэх замаар байгаль орчны хамгааллын ажлыг зохион байгуулах бөгөөд энэ тухай оператор компаниудтай хийсэн гэрээнд тодорхой тусгаж өгнө. Мөн оператор компаниудын үйл ажиллагаа төлөвлөлтийн зохион байгуулалтыг БОМТ-нд тодорхой тусгаж өгснөөр оператор компаниуд нь менежментийн төлөвлөгөөнд тусгасан хамгааллын төлөвлөлтүүдийг хэрэгжүүлэх үүрэгтэй болно.

1.4.2 Төслийн хог хаягдал, хог хаягдлын тодорхойлолт

Хог хаягдлын эх үүсвэр ба үндсэн менежмент. Төслийн бүтээн байгуулалтын хог хаягдлын гол эх үүсвэрүүд нь кэмпүүд буюу зам барилгын бүтээн байгуулалтын оператор компаниуд байна. Хог хаягдал гарах гол шалтгаан нь ажилчдын байршил, техникийн засвар үйлчилгээ байх тул хог хаягдлын менежментийг оновчтой зохион байгуулах зөвлөмж болон шаардлагыг төсөл хэрэгжүүлэгчээс оператор компаниудад хүргэж ажиллана. Энэ тухай БОМТ-нд тодорхой тусгаж өгнө өө.

Технологийн хог хаягдал. Төслийн бүтээн байгуулалтын үйл ажиллагаанаас үүсэх технологийн хог хаягдал болон орчны бохирдол нь үйл ажиллагаа болон техникийн үйлчилгээнээс гарах ба төрөл, ангилал нь энгийнээс аюултай хүртэл ангилагдана. Хатуу хог хаягдлыг ахуйн болон технологийн гаралтай гэж хоёр ангилж үзэж болох юм. Гарал үүслээс нь шалтгаалж эдгээр хаягдлыг зайлуулах, устгах арга хэлбэр ч ялгамжтай байх юм. Төсөл хэрэгжүүлэгч нь хатуу хаягдлыг гарал үүсэл устгах, зайлуулах хэлбэрээс нь хамааруулж түр цуглуулах, хадгалах талбайн арга хэлбэрийг төлөвлөсөн байх шаардлагатай.

Технологийн хатуу хаягдал. Төслийн хүрээнд үйл ажиллагаа явуулах битум болон цемент зуурах үйлдвэрээс гарах технологийн хатуу хаягдал нь дараах бүрдэлтэй байна. Үүнд:

- Авто техникийн сэлбэгийн хаягдал
- Уурын зуухын үнс

Авто техникийн сэлбэг хэрэгсэл. Төсөл хэрэгжих явцад 17 төрлийн авто хэрэгслийг ашиглах бөгөөд тэдгээрийн ашиглалт дууссан сэлбэг хэрэгсэл, хаягдал дугуй зэрэг техникийн Битумын сав баглаа боодол:

Сав баглаа боодол. Битумын сав баглаа боодол нь цаасан хэлбэртэй байдаг тул ахуйн хог хаягдалтай хамт зайлуулагдаж болно. Байгаль орчинд хор нөлөө багатай. хог хаягдал үүснэ.

Ахуйн хог хаягдал. Төсөл хэрэгжүүлэхэд оролцож байгаа ажилтнуудын хоол хүнс болон өдөр тутмын хэрэглээнээс үүдэлтэй хатуу хог хаягдал гарна. Зам барилгын ажлын оргил үед нэг кемпэд ойролцоогоор 50-100 хүн ажиллаж амьдрахаар төлөвлөгдсөн.


Хүснэгт 17. Ахуйн хог хаягдлын хэмжээ

Хэсэг	Нийт ажиллагсад	Нэг хүний өдөрт үүсэх ахуйн гаралтай хатуу хог хаягдал	Өдөрт үүсэх хатуу хог хаягдлын хэмжээ./кг /	Сард үүсэх хатуу хог хаягдлын хэмжээ./кг /	Жилд үүсэх хатуу хог хаягдлын хэмжээ. 7сар /кг /
Хэсэг-III	340	0.5 кг	170	5,100	35,700
Хэсэг-IV	300		150	4,500	31,500
Төсөл хэрэгжиж дуусах хугацаанд гарах хог хаягдал / 1 жилд буюу 2024 онд /			67,200 кг буюу 67.2тн		

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1 Төсөл хэрэгжих талбайн байршил, физик газарзүйн нөхцөл

Шинээр барихаар төлөвлөж буй Тавантолгойн уурхай-Цагаан дэл уул хилийн боомт чиглэлийн 270 км хүнд даацын авто замын трасс нь Тавантолгойн-БаруунНаран чиглэлийн 32км хатуу хучилттай авто замын төгсгөлийн эргэлтээс эхэлнэ.



Зураг 7. Төлөвлөж буй трассын дагуух газрын гадаргын байдал

2.2 Уур амьсгал, цаг уур

Төслийн хүрээнд баригдах 270 км урт хүнд даацын авто зам барих төслийн талбай орших бүс нутгийн уур амьсгал нь манай орны уур амьсгалын эх газарлаг шинж чанарыг бүрэн илэрхийлэх эрс тэс шинжтэй. Өөрөөр хэлбэл сэрүүн бүсийн эх газрын уур амьсгалын эрс тэс эх газарлаг шинж чанарыг илэрхийлсэн тодорхой ялгарсан жилийн дөрвөн улиралтай, өвөл нь хүйтэн, үнэмлэхүй бага температур нь -32.4°C хүрдэг, үнэмлэхүй их температур нь 42.2°C хүрдэг, үнэмлэхүй их бага температурын агууриг нь ($70.8-72.0^{\circ}\text{C}$) эрс тэс ялгаатай. Сүүлийн жилүүдэд бүс нутгийн хэмжээнд $0.1-0.5^{\circ}\text{C}$ -аар дулаарсан хандлагатай байна.

Хөрсний гадаргын дундаж температур нь ойролцоогоор $2.2-9.3^{\circ}\text{C}$ бол зуны улиралд хамгийн их температур нь 67.0°C , өвлийн улиралд -39°C хүрч байсан байх юм.

Ханхонгор сумын агаарын дулаан. Ханхонгор сумын агаарын дундаж температур 4.2°C /Сүүлийн жилүүдийн ажиглалтаар/ байдаг байна. Агаарын дундаж температур сүүлийн жилүүдэд 0.5°C -аар дулаарсан хандлагатай байна




График 1. Ханхонгор сумын агаарын дундаж температурын явц ба өөрчлөлт, жилээр

Хүрмэн сумын агаарын дулаан. Хүрмэн сумын агаарын дундаж температур 3.8°C байгаа ба агаарын дундаж температур сүүлийн жилүүдэд 1°C -аар дулаарсан хандлагатай байна.



График 2. Хүрмэн сумын агаарын дундаж температурын явц ба өөрчлөлт, жилээр

Номгон сумын агаарын дулаан. Номгон сумын агаарын дундаж температур 1.3°C /Сүүлийн жилүүдийн ажиглалтаар/ байдаг байна. Агаарын дундаж температур сүүлийн жилүүдэд 0.5°C -аар дулаарсан хандлагатай байна

Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Баруун нарангийн чиглэлийн 32 км автозамын төгсгөлөөс “Цагаан дэл уул” хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын автозамын төслийн байгаль орчны менежментийн 2026 оны төлөвлөгөө




График 3. Номгон сумын агаарын дундаж температурын явц ба өөрчлөлт, жилээр

2.3 Гадаргын ус

2.3.1 Усны сав газар

Төлөвлөж буй трассын зурвас нутаг нь Өвөрхангай аймгийн Дорноговь сумын 23.15 хувь, Дорноговь аймгийн нутгийн 62.45 хувь, Өмнөговь аймгийн нутгийн 33.13 хувь, Дундговь аймгийн нийт нутгийн 0.103 хувийг тус тус хамарна. Төслийн бүс нутгаас тус сав газарт Ханхонгор, Номгон, Хүрмэн сумдын нутаг хэсэгчилсэн байдлаар хамраана. Тус сав газарт гадаргын усны экологи-эдийн засгийн үнэлгээ 1420 төгрөг/шоо метр, газрын доорх усных 3996 төгрөг/шоо метр байдаг.


Хүснэгт 18. Төслийн бүс нутгийн усны сав газрын тодорхойлолт

<p>Галба-Өөш Долоодын говийн сав газар. Тус сав газар нь Сүхбаатар аймгийн нийт нутгийн 23.15 хувь, Дорноговь аймгийн нутгийн 62.45 хувь, Өмнөговь аймгийн нутгийн 33.13 хувь, Дундговь аймгийн нийт нутгийн 0.103 хувийг тус тус хамарна. Төслийн бүс нутгаас тус сав газарт Ханхонгор, Номгон, Хүрмэн сумдын нутаг хэсэгчилсэн байдлаар хамраана. Тус сав газарт гадаргын усны экологи-эдийн засгийн үнэлгээ 1420 төгрөг/шоо метр, газрын доорх усных 3996 төгрөг/шоо метр байдаг.</p>	<p>Алтайн өвөр говийн сав газар . Алтайн өвөр говийн сав газрын захиргаа нь Өмнөговь аймгийн Даланзадгад суманд 2014 онд байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна. Тус сав газарт Өмнөговь аймгийн нийт нутгийн 51.9 хувь, Баянхонгор аймгийн 46.4 хувь, Говь-Алтай аймгийн 54.6 хувь, Өвөрхангай аймгийн 7 хувь тус тас хамаарна. Өмнөговь аймгаас Баяндалай, Гурвантэс, Ноён, Номгон, Сэврэй, Хүрмэн, Баян-Овоо сумдын нутгууд хамаардаг байна. Тус сав газарт гадаргын усны экологи-эдийн засгийн үнэлгээ 1410 төгрөг/шоо метр, газрын доорх усных 4433 төгрөг/шоо метр байдаг.</p>
---	---

2.3.2 Төслийн бүс нутгийн гадаргын ус

Төслийн зурвас нутгаар жилд дунджаар 100 мм-ээс бага тунадас унах ба үүнээс дулааны улиралд 100 мм буюу түүнээс бага, өвлийн улиралд 10мм-ээс багагүй хур тунадас унана. Байнгын урсацгүй,хуурай,салхи ихтэй тус бүс нутагт гадаргын ус болон хөрсний чийг багатай байдгаас уурших усны хэмжээ бага, харин уурших боломжит хэмжээ манай орны хувьд хамгийн их байдаг онцлогтой тул ил задгай уснаас жилдээ 800-1000 мм ус ууршина гэсэн тооцоотой байдаг.

Сайруудын сав газрын эх харьцангуй өндөр уулсад байрших ба дунд хэсэгтээ говийн толгод, хотос хонхор зэрэг тогтоцтой. Сайр, судгийн голдиролд элс, элсэнцэр, жижиг хайрга зонхилох ба хэвгий харилцан адилгүй, сайрын эхээс адаг хүртэлх хэвгий дунджаар 5-10 промилль байна. Энэ нь сайруудын урсац эрс ялгарах нөхцөл болох бөгөөд үүнээс урсцын ширүүн болон тогтонги байдал шалтгаална.



Зураг 8. Монгол орны гадаргын усны сүлжээн дэх төслийн трассын байршил

2.4 Газрын доорх ус

Төслийн талбай нь геологийн нийлмэл тогтоцтой, янз бүрийн нас, найрлагын гүний биетүүдээр зүсэгдсэн, хагарлын системүүдээр хэрчигдсэн блоклог бүтэцтэй. Мөн түүнчлэн физик газар зүйн нөхцөлийн гол онцлог нь эдн дүйн эх газрын уур амьсгалтай, унах хур тунадасны хэмжээ бага, ууршилт нь хур тунадаснаасаа давдаг, байнгын урсацгүй, гадаргын усны нөөцгүй, гадаргын хувьд үндсэндээ нэгэн хэвийн буюу уулс хоорондын том, жижиг хотгор, хотос бүхий намхан бүхий намхан бэсрэг уул, толгод, товцог гүвээтэй, талархаг байдалтай. Энэ нь газар доорх усны байрлал, усан сүлжээ, тэжээгдлийн нөхцөл, химийн найрлага, тэдгээрийн тоо хэмжээ янз бүр байхад нөлөөлдөг. Үүс нутгийн хэмжээнд тархсан гипсометрийн янз бүрийн түвшинд орших артезийн сав газруудын зүсэлтийн дээд хэсэгт чөлөөт гадаргатай, доод хэсэгт ихэвчлэн даралтат ус тархсан ба гидрогеологийн давхарга зүйн ангиллыг судлаачид дараах үндсэн нэгжүүдээр ангилдаг. Үүнд:

- Нүх сүвний ус агуулагч дөрөвдэгчийн галавын сэвсгэр хурдасны үе давхарга
- Нүх сүв, нүх сув-ан цавын ус агуулагч мезозой, кайнозойн хурдас чулуулгийн бүрдэл
- Ан цавын болон хөндийжилтийн ан цавын ус агуулагч палеозой, протерозойн карбонат, терриген, түрмэл, бялхмал чулуулгийн бүс.

Газрын доорх усны тэжээгдлийн хэмжээ. Дээрх хүчин зүйлүүдээс хамааран газрын доорх усны байрлал, усан сүлжээ, тэжээгдлийн нөхцөл, химийн найрлага, тэдгээрийн тоо хэмжээ нь янз бүрийн байна. Судалгаа явуулсан талбайн хэмжээнд ангилагдсан үе, давхарга, цогцолбор, бүсүүдэд газрын доорх ус ямар нэг хэмжээгээр агуулагдах бөгөөд гидравлик шинж чанараараа газрын доорх ус нь чөлөөт гадаргатай ба даралтат гэж ангилагдаж газар доорх усны тэжээгдлийн хэмжээгээр нийт нутгийн хэмжээнд маш бага буюу жилдээ 5 мм/км²-ээс бага үзүүлэлттэй байх ба усны нөөцтэй орд бүхий хэсэгчилсэн газруудаар нөхөн сэргээгдэх нөөцийн хэмжээ 5-10 мм/км²-т хүрдэг байна.

- Цөлөрхөг хээрийн Цайварбор хөрс. Нам уулсын хоорондох талархаг гадаргаар мараалаг хөрстэй бүрдэл байдлаар элбэг тохиолддог. Хөрс үүсгэгч чулуулаг нь пролювийн мөлгөр гадаргатай чулуу, карбонатын хуримтлал ихтэй байна.
- Цөлөрхөг хээрийн элсэн хучаастай Цайварбор хөрс. Энэ хөрс бага зэрэг нам хотос газруудаар хармагийн довтой газраар ихэвчлэн тогтворжсон байх ба пролювийн гаралтай элс, элсэнцэр хурдас 5 см хүртэл зузаан хучаас үүсгэсэн байна.
- Цөлөрхөг хээрийн мараалаг, хужирлаг Цайварбор хөрс. Энэ хөрс цөлөрхөг хээрийн бор хөрстэй залгаж нам уулс, толгодын хоорондох өргөн нарийн хөндийн дундах нам хотос хэсгээр ердийн цайвар бор хөрстэй бүрдэл байдлаар алаг цоог тархалттай байна.
- Цөлийн Борсаарал хөрс. Энэ хөрс дээрх сумдын нутагт талархаг гадаргыг хамарч тархах ба гөлтгөнөт бор саарал хөрстэй бүрдэл байдлаар тогтворжсон байна.

2.6 Нөмрөг ургамал

Төслийн хүрээнд баригдах 270 км урт хүнд даацын авто зам барих трасс нь Монгол орны ургамал-газар зүйн тойргийн Өмнөд говь, Говь алтайн нуруу болон Алшаа говийн тойрог гэсэн 3 тойрогт хамаарч байна.

Төслийн хүрээнд баригдах 270 км урт хүнд даацын авто зам барих төслийн талбайн хэмжээнд 19 овгийн 33 төрөлд багтах нийт 84 зүйл гуурст ургамал бүртгэгдсэн ба амьдралын хэлбэрээрээ олон наст ургамал зонхилж байна.

График 4. Бүс нутагт тархацтай голлох ургамлуудын амьдралын хэлбэр



Нам толгодын ургамалжилт. Цөл болон цөлөрхөг хээрийн нам толгодын ургамлан бүлгэмдлийн тархац нь гадаргын өөрчлөлтөөс ихээхэн хамаарна. Ихэвчлэн нам толгодууд нь чулуурхаг байдаг нь ургамлын зүйлийн бүрдлийн хувьд ядмаг байдаг.

Түр зуурын урсгалтай голын гольдролууд, хуурай сайр болон давсархаг хотос хоолойнууд давсанд тэсвэртэй сөөг болон мод ургах нөхцөлийг бүрдүүлсэн байдаг учраас энэ хэсгүүдэд, марц, мараа давсархаг нугын ургамлан бүлгэмдлүүд тохиолдох нь элбэг. Цөлөрхөг хээр, цөлийн өргөн уудам тэгш тал ба нам толгод нь ган гачигт тэсвэртэй сөөг болон олон наст ургамлуудаар бүрхэгдсэн байдаг.

Түр зуурын урсгалтай сайрын ургамалжилт. Энэхүү түр зуурын урсгалтай голууд нь хаврын шар усны ус урсах, мөн хур бороотой үед усаар тэжээгдэж урсдаг байна. Трассын шугам олон тооны түр урсгалтай жижиг, том гольдролуудыг дайрч өнгөрдөг. Тур усгалтай голын дагуу нэг наст.аас эхлүүлээд олон наст, сөөг, заримдаг сөөгөнцөр, модлог ургамлууд ургана. Тэгш тал болон нам толгодуудын хооронд ургамлуудаас ялгаатай нь ус чийг байнга хангагдаж байдаг учраас зүйлийн хувьд арвин байдаг байна. Түр зуурын урсгалтай голын дагууд 3 бүлгэмдэл ялгарна.

Уул хоорондын хөндийн ургамалжилт. Энэ ургамалжилт нь ихэвчлэн уул хоорондын богино зайд оршино. Ургамлын тархац болон олон тооны зүйлүүдээс бүрдэнэ. Ихэвчлэн

богино хэмжээний жалга, судаг, тэгш гадаргатай газруудаас тогтоно. Бүлгэмдлийн хувьд хувирамтгай олон янзын бүлгэмдлийг үүсгэдэг байна.

Бүс дундын хэв шинж. Өндөр уул, ой, тайгын бүслүүр, хээр, цөлийн бүсийн алинд ч тохиолдож байдаг ургамалжлын хэв шинжийг, өөрөөр хэлбэл бие даан бүс бүслүүр үүсгэхгүй боловч хоёр ба түүнээс дээш бүс, бүслүүрт тохиолддог учраас түүнийг бүс дундын ургамалжил хэмээн нэрлэдэг. бөгөөд татмын нугын, хуурай нугын, цайдмын гэх үндсэн хэвшлийн ургамалжил байдаг. Төслийн бүс нутагт дэрст цайдмын хэв шинж нэлээдгүй тааралдана.

Ургамлын зүйлийн олон янз байдал. Дээрх хүснэгтэд тэмдэглэгдсэн зүйлийн бүрэлдэхүүнийг ургамлын амьдралын хэлбэрийг ялган үзвэл: Олон наст өвслөг 40 зүйл, Нэг наст. 21 зүйл, Заримдаг сөөгөнцөр 15 зүйл, сөөг 6 зүйл, Мод 2 зүйл ургамал тус тус бүртгэгдсэн. Тус бүс нутагт ховрын статустай, Мөнх харгана- *ammiopiptanthus mongolicus* нэлээдгүй тархалттай бөгөөд трассын туршид 20 гаружай км уртаар тус ховор ургамлын тархац нутаг үргэлжилнэ. Трассын талбайд төсөл хэрэгжүүлэгчийн захиалгаар хийсэн хээрийн судалгааны үр дүнд тулгуурлан ургамалжилтын ангилааг гаргасан судлаач П.Ариунсүрэнгийн хийсэн мониторинг судалгааны тайлан бий.

2.7 Ойн сан

Галба-Өөш, Долоодын сав газарт зөвхөн говь цөлийн бүсийн заган ойн хэлбэр тохиолдоно. Үүнд тус сав газарт багтсан Өмнөговь аймгийн Баян-Овоо, Манлай, Номгон, Ханбогд гэх 4 сум, Дорноговь аймгийн Сайншанд, Мандах, Улаанбадрах, Хатанбулаг, Хөвсгөл гэх 5 сумын нутаг хамаарагдаж байна. Галба-Өөш, Долоодын сав газрын бүрэлдэхүүнд багтсан Сүхбаатар аймгийн хувьд зөвхөн Дариганга сумын нутагт багахан талбайд байгалийн болон тармаг ой, ойжуулсан талбай ноогдож байна.

Галба-Өөш, Долоодын сав газрын заган ойн сангийн **нийт талбай 439686 га**, харин заган ургаа ойн нөөцийн хэмжээ **нийт 146781.94 мян. м³** байна.

2.8 Амьтны аймаг

Тавантолгойн уурхай-Цагаан дэл уул хилийн боомт чиглэлийн 270 км хүнд даацын хатуу хучилттай авто зам барих төсөл хэрэгжих газар нутаг нь Монгол орны амьтны аймгийн газарзүйн мужлалаар Монгол-Төвдийн муж, Алтайн Өвөр говийн тойрогт хамаарна.

Хүснэгт 19. Хөхтөн амьтдын хамгаалагдсан байдал

Зүйлийн нэр	Шинжлэх ухааны нэр	Монгол улсын	CITES* I, II	IUCN Red List	Global category	Монгол улсын	Улаан данс	CMS** I, II
		ховор амьтны	хавсралт	(2006)		улаан ном	(2006)	хавсралт
ХОВОР, ХОВОРДСОН ХӨХТӨН АМЬТАД								
Хар сүүлтий	<i>Gazella subgutturosa</i>	+	-	ЭМ	+	ЭМ	II	
Хулан адуу	<i>Equus hemionus</i>	+	-	ЭМ	+	ХБ	II	
Тавруу атигдаахай	<i>Cardiocranius paradoxus</i>	-	-	ЭМ	-	МД	-	
Өөхөн сүүлт атигдаахай	<i>Salpingotus crassicauda</i>	-	-	ЭМ	-	МД	-	
АГНУУРЫН ХӨХТӨН АМЬТАД								

Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Баруун нарангийн чиглэлийн 32 км автозамын төгсгөлөөс “Цагаан дэл уул” хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын автозамын төслийн байгаль орчны менежментийн 2026 оны төлөвлөгөө

Зүйлийн нэр	Шинжлэх ухааны нэр	Монгол улсын ховор амьтны	CITES* I, II хавсралт	IUCN Red List (2006) Global category	Монгол улсын улаан ном	Улаан данс (2006)	CMS** I, II хавсралт
Боролзон туулай	<i>Lepus tolai</i>	-	-	AӨ	-	AӨ	-
Бозлог зурам	<i>Spermophilus pallicauda</i>	-	-	AӨ	-	AӨ	-
Саарал чоно	<i>Canis lupus</i>	-	II	AӨ	-	ХБ	-
Шар үнэг	<i>Vulpes vulpes</i>	-	-	AӨ	-	ХБ	-
Хярс үнэг	<i>Vulpes corsac</i>	-	-	AӨ	-	ХБ	-
ЖИЖИГ ХӨХТӨН АМЬТАД							
Дэлдэн зараа	<i>Hemiechinus auritus</i>	-	-	AӨ	-	AӨ	-
Орог зусаг	<i>Phodopus campbell</i>	-	-	AӨ	-	AӨ	-
Элссэг зусаг	<i>Phodopus roborovskii</i>	-	-	AӨ	-	AӨ	-
Зээрд сохдой	<i>Ellobius tancrei</i>	-	-	AӨ	-	AӨ	-
Хадны барагчин	<i>Alticola semicanus</i>	-	-	AӨ	-	AӨ	-
Цайвар үлийч	<i>Lasiopodomys brandtii</i>	-	-	AӨ	-	AӨ	-
Шаргал чичүүл	<i>Meriones meridianus</i>	-	-	AӨ	-	AӨ	-
Хул чичүүл	<i>Meriones meridianus</i>	-	-	AӨ	-	AӨ	-
Бор шишүүхэй	<i>Cricetulus migratorius</i>	-	-	AӨ	-	AӨ	-
Цомц шишүүхэй	<i>Allocricitulus curtatus</i>	-	-	AӨ	-	AӨ	-
Гэрийн хулгана	<i>Mus musculus</i>	-	-	AӨ	-	AӨ	-
Шивэр алагдаага	<i>Allactaga sibirica</i>	-	-	AӨ	-	AӨ	-
Говийн алагдаага	<i>Allactaga bullata</i>	-	-	ХБ	-	МД	-
Элсч савагдаахай	<i>Dipus sagiita</i>	-	-	AӨ	-	AӨ	-

Хулан адуу. Монголын өмнөд хэсэг хялгана-таанат, хялгана-баглуурт говь, цөлөрхөг хээрт тархан амьдарна. Одоо Зүүн гарын, Алтайн өвөр говь, Өмнөговь, Дорноговийн баруун хэсэг, Дундговийн урд хэсэгт л бий. Биологийн хүрээлэнгээс 2003 онд хийгдсэн судалгаагаар Монгол орны хулан адуу тархсан 177563 ам км нутагт 20000 толгой хулан байгаа гэж тоолсон ба нийт тархалтын 67 хувь нь Дорноговь, 20 хувь нь Өмнөговь, 13 хувь нь Ховд, Говь-Алтай, Баянхонгор аймгийн нутагт байна.



Зураг 10. Equus hemionus – Хулан адуу¹

¹ “Эс И Си” ХХК-ий архиваас

Хар сүүлтий. Хар сүүлтий нь элсэрхэг болон чулуурхаг тэгш тал газар тархан нутаглана. Монгол орны цөлөрхөг хээр, цөлийн бутлаг, өвслөг ургамал бүхий аараг толгод, дэнж, хөндий дагаж байршина. Хар сүүлтий улирлын чанартай нүүдэллэж амьдарна.

Зураг 11. *Gazella subgutturosa* – Хар сүүлтий



Монгол улсын амьтны аймгийн тухай хууль (2000), Засгийн газрын тогтоолоор (2001 оны №264) ховор зэрэглэлээр хамгаалалтад авсан (Бадам, Ариунзул, 2005) байдаг.

Монгол улсын ан агнуурын тухай 1995 оны хуулиар энэ зүйлийг ховор зэрэглэлд оруулсан (БОЯ, 1996). тархац нутгийнх нь 15 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг. Нэлээд удам тархацтай боловч нягтшил нь бага төслийн бүсэд Алашань говьд элбэг тархсан (Банников, 1954; Соколов, Орлов, 1980; Амгалан, 1984,1986; Lkhagvasuren et al, 1999).

Шувуудын зүйлийн бүрдэл. Төслийн талбай орчмын бүс нутагт 3 багт хамаарагдах нийт 15 зүйл шувуу тархан амьдарч байна. Тус нутагт ховор тохиолдох зүйлийн тоонд шар шувуу, хон хэрээ, жороо тоодог зэрэг 3 зүйл (14.2%) тохиолддог байна. орчимд тархсан зарим шувуудын Монгол улсын болон олон улсын хууль тогтоомжоор хамгаалагдсан зүйлийн жагсаалтыг гарган хүснэгтээр харуулав.

Хүснэгт 20. Төслийн бүс нутагт тархсан шувуудын хамгаалагдсан байдал

№	Латин нэр	Монгол нэр	Монгол улсын улаан ном	Амьтны аймгийн тухай хууль	CITES I, II хавсралт	CMS I, II хавсралт
1	<i>Milvus migrans</i>	Сохор элээ	-	-	+	+
2	<i>Buteo rufinus</i>	Талын сар	-	-	+	-
3	<i>Aegyptus monachus</i>	Тас	-	-	+	+
4	<i>Falco cherrug</i>	Идлэг шонхор	-	-	+	+
5	<i>Falco tinnunculus</i>	Начин шонхор	-	-	+	-
6	<i>Anthropoides virgo</i>	Өвөгт тогоруу	-	-	+	-
7	<i>Bubo bubo</i>	Шар шувуу	+	-	+	-
8	<i>Athena noctua</i>	Хотны бүгээхэй	-	-	+	-

3. ТӨСЛИЙН СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1 Төслийг хэрэгжүүлэх үе шат

Төслийн бүтээн байгуулалтыг 2 жилийн хугацаанд хийж гүйцэтгээд 3 дахь жилээс ашиглалтад шилжүүлэх төлөвлөгөөтэй байгаа ба 2025 онд төслийн замын бүтээн байгуулалтыг эхлүүлж чадаагүйгээс шалтгаалан хэрэгжилтийн хугацаа доор үзүүлсэн бүдүүвчийн үзүүлэлтээс бүтэн 1 жилээр хойшилж байгаа болно.



Зураг 12. Төслийн хөгжлийн үе шатууд, ТЭЗҮ дэх төлөвлөлтөөр

3.2 Төслийн сөрөг нөлөөллийн тодорхойлолт

3.2.1 Замын ерөнхий төлөвлөлтөд тавигдах шаардлага

Төлөвлөж буй автозамын ерөнхий төлөвлөлтийг хуримтлуулагч, 2Б зэрэглэлийн автозамын шаардлагад шаардлагад нийцтэй байдаг нь тодорхойлоод төслийн Төслийн ТЭЗҮ-д үндэслэсэн болно. төлөвлөж буй замын төлөвлөлт ангиллын замыг барьж байгуулах гол шаардлагуудыг хангасан байх нь төслийн хүрээний эрсдэлийг бууруулах, хянах ач холбогдолтой.

Хүснэгт 21. Төслийн замын ерөнхий төлөвлөлтөд тавигдах шаардлага ба тодорхойлолт

№	Зам барилгын гол шаардлагууд	Төлөвлөлт	Шаардлагад нийцсэн байдал
1	Замын зурвас.	Замын зурвасын өргөнийг Авто замын тухай хуулийн 16.2 зүйлийн дагуу 100 м (замын тэнхлэгээс хоёр тийш 50м) байхаар сонгосон.	Төслийн замын дагуух газрын ашиглалтын өнөөгийн байдал нь замын зурвасын өргөнийг чөлөөтэй сонгох бололцоотой
2	Тээврийн хэрэгслийн овор хэмжээ, Зүтгүүр, хагас чиргүүл бүхий авто угсрааны зөвшөөрөгдөх дээд хэмжээгээр	18.9 м-ээс ихгүй байна. 36.5 м-ээс ихгүй байна.	<ul style="list-style-type: none"> • “Хүнд даацын авто тээврийн хэрэгсэлд тавигдах техникийн ерөнхий шаардлага” MNS6278-2011-д тусгаснаар:

Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Баруун нарангийн чиглэлийн 32 км автозамын төгсгөлөөс “Цагаан дэл уул” хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын автозамын төслийн байгаль орчны менежментийн 2026 оны төлөвлөгөө

№	Зам барилгын гол шаардлагууд	Төлөвлөлт	Шаардлагад нийцсэн байдал	
3	Тээврийн хэрэгслийн овор хэмжээ, Зүтгүүр авто машины өргөнөөр	2.5 м, ачаалсан өндөр (тэвшний өндөр) 3.8 м-ээс илүүгүй байна.	<ul style="list-style-type: none"> Хүнд даацын зүтгүүр автомашин, хагас чиргүүл, чиргүүл бүхий авто угсрааны бүх жингийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ бий. 	
4	Тээврийн хэрэгслийн овор хэмжээ, Чиргүүл болон хагас чиргүүлийн зөвшөөрөгдөх өргөнөөр	2.7 м-ээс илүүгүй байна.		
5	Хөндлөн огтлолын параметр.	Хөдөлгөөний нэг зурвас нь 3.7м өргөнтэй, хоёр зурваст зам (нийт өргөн 7.4м)	Төслийн авто замаар овор ихтэй хүнд даацын автомашин зорчих бөгөөд “Авто зам төсөллөх” ЗЗБНБД 22-004-2016-ийн дэд зүйл 13.11-д зааснаар:	
		3.8м өргөнтэй хөвөө, үүнээс 0.3м нь бэхлэгээтэй хөвөө		
6	Далан болон ухмал.	Замын далан 0.40 м-ээс багагүй өндөртэй. Ухмалын хажуу налуу 1м-ээс их үед өөрийн шуудууны ирмэгээс 4м дэвсгэ гаргана. Замын далан болон ухмалын хажуу налуу зүлэг ширгээр бэхлэх боломжгүй тул нүхт эко хавтангаар бэхэлнэ	“Автозам төсөллөх” ЗЗБНБД 22-004-2016 ба Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл БНБД 23-03-04 стандартын шалгуур, төслийн замын газар нутгийн уур амьсгалын ИВ, ША, ШВ дэд бүсүүдийг дайран өнгөрөх нөхцөл, өвлийн улиралд унах хур тунадасны нийлбэр, мөстлөгийн хэмжээ зэргийг тооцоноор	
7	Ус зайлуулах шуудуу болон хоолой.	Шуудууны дагуу налуу 4%-иас бага тохиолдолд байгалийн хөрсөн шуудуу, дагуу налуу 4%-иас их тохиолдолд 20см зузаантай цементэн зуурмагтай чулуун бэхлэгээтэй шуудуу хийнэ.	Ус зайлуулах шуудууны ажилд замын өөрийн шуудуу, уулын шуудуу, ус цуглуулах шуудуу, усны хурд сааруулах шуудууг багтаасан.	
		1.0x1 хэмжээний диаметртай дугуй хоолой 138 байх бол,		Трассын дагууд нийтдээ 464 цэгт төмөр бетон хоолой төлөвлөгдсөнөөс томхон сайруудад 1-5 хувийн хангамшилтай урсцын тооцоо хийсэн.
		1.0x1.0x1-ээс 4.0x4.0x2 хүртэл хэмжээтэй дөрвөлжин хоолой 328		
8	Гүүр.	Зүүн сайхны нуруу, Хан уулаас эхтэй үерийн усны сайр нь Км44+840 байрлалд төслийн замтай огтлолцох тул нуурыг тэжээж байдаг энэхүү сайрыг хөндөхгүйгээр тус байрлалд 18м-ийн алгасал, урт бүхий гүүр төлөвлөсөн.	Төслийн авто замын Км44+840 байрлалд авто замын трасс нь Балгасын Улаан нуурын хойд талаар 5 км зайтай өнгөрдөг ба Балгасын Улаан нуур нь байнгын урсгалтай голоор тэжээгддэггүйг тооцсон.	
9	Ус давуулах далан	66 байрлалд үерийн усыг давуулах далангаар зам дээгүүр өнгөрүүлэхээр төсөллөсөн.	Үерийн усны нөлөөгөөр түр урсацтай сайр жалгуудад гүүр төлөвлөх нь эдийн засгийн үр ашиггүй байсан.	
10	Замын хучилтын хийц.	Төслийн авто замын бетон хучлагыг С40 маркийн цементбетоноор хийж гүйцэтгэх	ЗТБХБСайдын 2010 оны 313 дугаар тушаалаар батлагдсан “Монгол орны асфальтбетон хучлагатай авто	

Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Баруун нарангийн чиглэлийн 32 км автозамын төгсгөлөөс “Цагаан дэл уул” хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын автозамын төслийн байгаль орчны менежментийн 2026 оны төлөвлөгөө

№	Зам барилгын гол шаардлагууд	Төлөвлөлт	Шаардлагад нийцсэн байдал
		ба замын тэнхлэгийн дагууд дагуу заадас, 4.5м-ийн алхамтайгаар агшилтын заадас, 27м-ийн алхамтайгаар тэлэлтийн заадастайгаар тооцсон.	замын хучилтын хийцийн жишиг цомог”-ийг жишиг болгож тээврийн хэрэгслийг стандарт тэнхлэгийн ачаалалд шилжүүлэн үзэхэд 549.16 сая стандарт тэнхлэг (ESAL) болохоор тооцсоноор

3.2.2 Төслийн хүрээнд үүсэх нөлөөллийн тодорхойлолт

Хүснэгт 1. Төслийн хүрээнд карьер ашиглах үйл ажиллагаанаас үүсэх нөлөөллийн тодорхойлолт

№	Төслийн хэрэглээ	Нөлөөллийн тодорхойлолт
Нэг. Ашигт малтмалын ордоор нь авч үзвэл		
1	шорооны 28 орд буюу нийт ордын 68.3хувь	<ul style="list-style-type: none"> Зам барилгын даланд дэвсэх шороо авснаар тухайн газар хонхор хотгор үүсэх газар дүрсийн өөрчлөлт үүснэ. Өөрчлөлтийн хэмжээ тухайн карьераас ашигласан нөөцийн хэмжээнээс хамаарна. Хэлбэршүүлэн нөхөн сэргээх боломжтой.
2	чулууны 7 орд буюу нийт ордын 17.1хувь	
3	Элсний 6 орд буюу нийт ордын 14.6 хувь	
Хоёр. Байшил, харьяаллаар нь авч үзвэл		
4	36.6 хувь буюу 15 нь Ханхонгор суманд	<ul style="list-style-type: none"> Төслийг эхлүүлэхэд бүтээн байгуулалтад зурвас газрыг чөлөөлөх шаардлага үүснэ. Цаашид замын ашиглалтын үед оршин суугчдыг дасан зохицох хөтөлбөрт хамруулна. Хүнд машин, механизмын дуу чимээ бүтээн байгуулалт, ашиглалтын аль ч үед нөлөөлнө.
5	41.4 хувь буюу 17 нь Хүрмэн суманд	
6	22.0 хувь буюу 9 нь Номгон суманд	
Гурав. Ашиглалтын талбайгаар нь авч үзвэл		
7	68.3 хувь нь буюу 28 нь 12 га ашиглана.	<ul style="list-style-type: none"> Газар шорооны ажил хийгдэж газар-хөрс-ургамал эвдэрнэ. Зам барилгын бүтээн байгуулалтын үед их хэмжээний тоос дэгдэх ба эх үүсвэр нь карьерууд-тээврийн зам-баригдаж буй зам байна.
8	31.7 хувь нь буюу 13 нь 16 га ашиглана.	
Дөрөв. Орд газрын ашиглалтын технологиор		
9	Элсний болон шорооны ордыг шимт хөрсийг хуулсны дараа ухашлан ачиж зам барилгад шууд ашиглана.	<ul style="list-style-type: none"> Газар шорооны ажил хийгдэж газар-хөрс-ургамал эвдэрнэ. Карьер ашиглах үед их хэмжээний тоос дэгдэнэ. Техникийн ашиглалтын дуу чимээ тархана. Газар шорооны ажил хийгдэж газар-хөрс-ургамал эвдэрнэ. Карьер ашиглах үед доргилт, чичирхийлэл, их хэмжээний дуу чимээ үүсэх нь тодорхой давтамжтай Чулууны шидэлт мөн их хэмжээний тоосны эрчимтэй, цар хүрээтэй тархалт үүснэ. Эрсдэлийн нөхцөл өндөрсөж, анхаарал шаардана.
10	Чулууны ордод чулуун хурдсыг тэсэлгээгээр сийрүүлсэн сулласны дараа бутлах үйлдвэр рүү зөөж зам барилгад зориулан буталж жижгэрүүлнэ.	

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1 Ерөнхий зүйл

4.1.1 БОМТ-ний гол зорилго

Энэхүү төлөвлөгөөний зорилго нь 2026 онд явагдах Эрдэнэбулаг-Цагаандэл уул чиглэлийн 155.2 км авто зам барих барилгын ажлын үед байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, ерөнхий үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх, байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд үр дүнтэй байгаа эсэхийг тогтооход оршино.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль Орчин Аялал Жуулчлалын Сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-д заагдсан бүтэц, агуулга, аргачлалын дагуу боловсруулав.

4.1.2 Байгаль орчны менежментийн 2026 оны төлөвлөгөөний нийт зардал

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих, тайлагнах эрх үүргийг төсөл хэрэгжүүлэгч байгууллага болох “Ундрах Говь” ХХК хүлээх бол БОМТ-д заагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажиллах үүргийг зам барилгын ажлын гэрээт гүйцэтгэгч байгууллагууд хүлээнэ. БОМТ-г хэрэгжүүлэх төсөв зардлыг барилгын ажлын гэрээнд тусган оруулж өгөх бөгөөд гэрээт гүйцэтгэгч байгууллагууд нь барилгын ажлын явцад талбайн байгаль орчны ажилтан авч ажиллуулах үүргийг хүлээнэ. 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал 108.5 сая төгрөг болох бөгөөд зардлыг доорх хүснэгтэд ангилан үзүүлэв.

Хүснэгт 22. БОМТ-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх нийт зардлын бүтэц, хуваарилалт


№	Менежментийн гол арга хэмжээ	5 жилийн нийт зардал	
		төгрөг	хувь
1	Сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээ	18,660,000.00	17.2
3	Биологийн олон янз байдлыг хамгаалах	40,200,000.00	37.1
4	Нүүлгэн шилжүүлж, нөхөн олговор олгох	7,300,000.00	6.7
5	Түүх соёлын өвийг хамгаалах	16,448,000.00	15.2
6	Осол, эрсдэлийн менежмент	2,688,000.00	2.5
7	Хог хаягдлыг менежмент	9,100,000.00	8.4
8	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	13,308,000.0	12.3
9	Олон нийтийн оролцоог хангах	750,000.00	0.7
ДҮН		Төгрөг	108,486,000.000
		Хувь	100.0

4.2 Байгаль орчны менежментийн гол төлөвлөлтүүд

4.2.1 Сөрөг нөлөөг бууруулах төлөвлөгөө

Газарт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах. БОННУ-ний 2 болон 3-р бүлэгт заасны дагуу төсөл нь газар эзэмшил, ашиглалттай холбоотой баримт бичигт дурдсан төлөвлөлтийн дагуу бүтээн байгуулалтыг хийнэ. Төсөл хэрэгжүүлэгч зам барилгын бүтээн байгуулалтын ажилд оператор компаниудтай хамтран ажиллах оператор компаниудын кемп байрших талбайн зөвшөөрлийг харьяа аймаг болон сумын захиргаанаас авна. Үүнд 2026 оны хувьд:

- Зам барилгын ажилд шаардлагатай карьер ашиглалтын зөвшөөрөл
- Оператор компаниудыг түр болон удаан хугацаагаар байршуулах газрын зөвшөөрөл зэргийг авна.



Зураг 13. Оператор компаниудын кемпийн газар ашиглах төлөвлөлтийн загвар

Зам барилгын бүтээн байгуулалтын үед технологийн болон бүтээн байгуулж буй замуудаар хөдөлгөөн хийх зам барилгын машин механизмын хөдөлгөөний ургсгал, орон нутгийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний зохицуулалтыг хангах үүднээс замын тэмдэг, тэмдэглээг байнга шинэчлэн, зөөвөрлөж тавина.

Агаарт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах. Төслийн агаар бохирдуулах гол эх үүсвэр нь бүтээн байгуулалтын үеийн тоосны дэглэлт байх бөгөөд тэр нь 2 жилээр үргэлжилнэ. Газар шорооны ажлаас үүсэх тоосны сөрөг нөлөөг бүтээн байгуулалтын хугацаанд усалгаа хийх, тоос барих замаар бууруулах ба карьерийн гадаад овоолго, ашиглаад дууссан карьерийг хэлбэршүүлсний дараа сул шороо хийсэхээс хамгаалж дасмаг цацаж царцаах замаар тоосны тархалтыг бууруулна.

Хог хаягдлын бохир цэгийн орчинд үнэргүйжүүлэх арга хэмжээ авч ариутгал хийж, халдварын эсрэг дэглэм баримтална.

Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах. Төсөл хэрэгжүүлэгч нь усны хэрэгцээгээ гүний уснаас хангах тул “Усны тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах шаардлагатай. Үүнд:

- Цооног гаргуулах, худгийн паспорт авах тухай
- Ус ашиглуулах дүгнэлт гаргуулах тухай
- Ус ашиглах зөвшөөрөл, эрхийн бичиг олгож гэрээ байгуулах тухай зэрэг асуудлыг “Усны тухай хуульд хэрхэн зохицуулсан талаар дэлгэрэнгүй өгүүлсэн.

Цаашид төсөл хэрэгжүүлэгч нь ус ашиглах үедээ усны нөөц болон чанарт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахдаа Усны тухай, Ус бохирдуулсан төлбөрийн тухай хуулиуд болон БОННУ-ний тайланд дурдсан стандартуудыг мөрдөж ажиллана.

Хөрс, ургамалд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах. Тайланд дурдсан сөрөг нөлөөг бүтээн байгуулалтын дараа ногоон бүс тохижуулах замаар арилгах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүний тулд:

- Бүтээн байгуулалтыг хийж эхлэх үед шимт хөрсийг хуулахдаа “Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт” MNS5916:2008 стандартыг баримтлах ба шимт хөрсийг 28-30 см зузаантай хуулж тусад нь овоолон хадгална. Бохирын шугам байгуулахад гарах бага хэмжээний хурдас чулуулгийг шимт хөрстэй хамт хадгалж хожмын нөхөн сэргээлтэд ашиглахаар тооцон дасмаг цацаж царцаан хадгана.
- Хуулж хадгалсан шимт хөрсийг бүтээн байгуулалтын дараа ногоон бүс тохижуулахдаа хүртээмжийнх нь байдлаас шалтгаалан бнз бүрийн зузаанаар дэвсэж хэрэглэх бөгөөд шимт хөрсний дэвсэлтийг 15-см -ээс хэтрүүлэхгүй.
- Ховрын статустай мөнх ногоон харгана трассын дагууд 20 гаруй км уртад нөлөөлөлд өртөх тул нөлөөлөлд өртөөгүй хэсгүүдээс Монгол мөнххарганы үрийг боловсорч гүйцсэн үед нь түүж, хожмын нөхөн тарилтад ашиглахаар бэлтгэнэ. 2026 онд 20 хүртэл кг үрийн нөөц бэлдэж соёлолтыг тодорхойлон хадгална.
- Тус бүс нутаг нь хуурай, эмзэг экосистемтэй, хөрс-ургамлын бүрхэвчийн нөхөн сэргэх чадвар харьцангуй сул нутагт хамаарах бөгөөд замын трассын төлөвлөлт, барилгын ажлын үед ургамалжил, хөрсний эвдрэл, тоосжилт, бэлчээрийн доройтолд онцгой анхаарах шаардлагатай тул бүтээн байгуулалтын үед зураг төслөөс илүүц газар талбайг эвдэхгүй байх, ховор ургамал, заган ойтой хэсгүүдэд нарийсгасан хамгаалалтын зурвас тогтоон ажиллана.
- Ариутгал халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагатай хамтран гэрээ байгуулан хогийн цэг болон цэвэрлэх байгууламжийн орчинд ариутгал халдваргүйжүүлэлтийг байнга хуваарийн дагуу хийж хөрсний бохирдлоос сэргийлнэ.
- Шатах тослох материалаар бохирдсон хөрсийг тусгайлан бэлдсэн мембран дэвсэг бүхий нүхэнд хуримтлуулан хучиж хадгалж байгаад саармагжуулах арга хэмжээ авна. Саармагжсан хөрснөөс дээж авч шинжилгээнд хамруулсны дараа

Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Баруун нарангийн чиглэлийн 32 км автозамын төгсгөлөөс “Цагаан дэл уул” хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын автозамын төслийн байгаль орчны менежментийн 2026 оны төлөвлөгөө

шинжилгээний дүнд үндэслэн байгаль нийлүүлэх, эсвэл аюултай хог хаягдалтай хамт зайлуулах арга хэмжээг авна.

Сөрөг нөлөөг бууруулах төлөвлөлтийг хэрэгжүүлэх зардал. Сөрөг нөлөөг бууруулах зөвлөмжийн хэрэгжүүлэхэд төсөл хэрэгжүүлэгч 130.0 гаруй сая төгрөгийн нэмэлт гаргана.

Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Баруун нарангийн чиглэлийн 32 км автозамын төгсгөлөөс “Цагаан дэл уул” хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын автозамын төслийн байгаль орчны менежментийн 2026 оны төлөвлөгөө

Хүснэгт 2. Сөрөг нөлөөг бууруулах төлөвлөгөө

№	Сөрөг нөлөөллүүд	Хамгааллын арга хэмжээ	Сөрөг нөлөөний хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа	Мөрдөх баримт бичиг
1	Зам барилгын ажлаас үүсэх газрын эвдрэл	Зураг төслийг баримтлан ажиллах	155.2 км бүхий 3 болон 4-р багцийн трассын дагуу	Оператор 4 компани	ТЭЗҮ, зураг төслөлд заасан орон зайд ажиллана.			2026-2027 онд	ТЭЗҮ% зураг төсөл
		Карьер болон кемп ашиглалтын газрын зөвшөөрөл авах	Түгээмэл тархацтай ашигт малтмалын талбай, кемпийн ашиглалтын талбай	Кемпийн болон карьерийн байршлын тоогоор	Ажил хариуцсан мэргэжилтний цалин хөлсөнд тооцогдсон.				ТЭЗҮ, замын зураг төслийн эдийн засгийн тооцооны хэсэг
		ашиглалттай газрын тэмдэг тэмдэглэгээ	Бүтээн байгуулалт хийж буй орчин, тээврийн хэсэг	Усны хэмжээ куб м	15,000.00	120	1,800,000.00	2026-2027 онд	БОННУ-ий тайлан
2	Бэлчээрийн хуваагдал	малын гарам, гарцын оновчтой байршил	Оршин суугчдын суурьшил, ус бэлчээрийн хуваагдал	Нэг түвшний 11 гар, малын 20 гарц хийнэ	Зам барилгын бүтээн байгуулалтын технологийн зардалд туссан.			2026-2027 онд	ТЭЗҮ, замын зураг төсөл, 3 болон 4-р багц
3	Агаар орчны бохирдол	Карьер ашиглалтаас үүсэх тоосыг усалж дарах	Карьер ашиглалтын орчин	Байршил тогтоосон 41 карьер	120,000.00	41	4,920,000.00	Бүтээн байгуулалтын хугацаанд	Агаарын тухай хууль Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль MNS458552016 Агаарын чанар, Техникийн шаардлага
		Шороон замын усалгаа	Тээврийн хэсэг	Бүтээн байгуулалтын үеийн ашиглалтын замууд	36,000.00	190	6,840,000.00	II ба III улиралд	
		Ашиглаад дууссан карьер овоолгод дасмаг шүршиж царцаах	Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалт	Карьерийн тоогоор	121,428.6	42	5,100,000.00	2026-2027 онд онд	

Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Баруун нарангийн чиглэлийн 32 км автозамын төгсгөлөөс “Цагаан дэл уул” хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын автозамын төслийн байгаль орчны менежментийн 2026 оны төлөвлөгөө

		Агаар бохирдуулсны төлбөр төлөх	Хүнд машин механизмын ашиглалт	Оператор 4 компани	Оператор компаниудын үйл ажиллагааны зардалд тооцогдоно.	2026онд	
4	Гадаргын усны болзошгүй бохирдол	Зам барилгын үеийн хяналт, мониторинг	Зам барилгын үеийн бохирдсон урсац	Төмөр бүтөн хийцтэй нийт 20 хоолой	Хяналт мониторингийн зардалд тооцогдоно	2026-2028 онд	Усны тухай хууль, MNS0900052018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар.
		Шингэн бохирын болзошгүй асгаралт	ШТС-ын болон техникийн парклалт, зогсоолын байршлаар	Кемпүүдийн тоогоор	Осол, эрсдэлийн менежментээс тооцогдоно.	2026-2028 онд	
		Хог хаягдлын болзошгүй тархалт	Хог хаягдлын цэгүүдийн байршлаар	Оператор компаниудын кемпийн байршлаар	Оператор компаниудын хог хаягдлын менежментэд тооцогдоно.	2026-2028 онд	
5	Газар доорх усны ашиглалтаас үүсэх нөлөө	Дутмаг усны нөөцийг хангах	Байршил тогтоосон 8 худгийг шинээр гаргах	Байршил бүхий 4 худаг	Төслийн хөрөнгө оруулалтын зардалд тооцогдсон бий.	2026-2027 онд	
		Ус ашигласны төлбөр төлөх	Шинээр гаргасан 4 худгаас ус ашиглах	Усны сав газартай байгуулсан 8 гэрээгээр	Ус ашиглах зөвшөөрлөөр ашигласан усны төлбөр төлөх бөгөөд үйл ажиллагааны зардалд жил бүр тусгагдана.	2026-2027 онд	
Сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх зардлын дүн						18,660,000.00	

4.2.2 Биологийн олон янз байдлыг хамгаалах арга хэмжээний төлөвлөлт

Монгол Мөнххарганад үзүүлэх нөлөөллийг бууруулах. Монгол мөнххаргана-*Ammopiptanthus mongolicus* нь устах аюулд ойрхон зүйлд тооцогддог. Говийн цөлийн мөстлөгийн үеэс үлдсэн “амьд үлдэгдэл” (relict species) бөгөөд тархац нь маш хязгаарлагдмал, нөхөн сэргэх чадвар удаан тул эмзэг ангилалд ордог үнэхээр онцгой ургамал байна. Навч нь өвлийн улиралд ч ногоон байдаг, хуурай бүс нутагт бусад ургамал багасах үед орлуулах тэжээл болдог онцлогтой. Ардын уламжлалт анагаах ухаанд хэрэглэж ирсэн, үрэвслийн эсрэг Антиоксидант үйлчилгээтэй нэгдлүүд агуулдаг гэх боловч орчин үеийн эмнэлзүйн хэрэглээ харьцангуй хязгаарлагдмал тул судалгаа үргэлжилж байгаа гэж үздэг байна.



Зураг 14. Монгол мөнххаргана-*Ammopiptanthus mongolicus*

Монгол мөнххаргана (*Ammopiptanthus mongolicus*)-д “өндөр хамгаалалт” хэрэгтэй байгаа шалтгаан нь зүгээр нэг ховор ургамал гэдгээс илүү экосистемийн хувьд маш эмзэг, нөхөн сэргэх чадвар сул, тархац маш жижиг байдагтай холбоотой.

Хүснэгт 23. Монгол мөнххарганы хамгааллын бодлогын суурь

Энэ ургамалд өндөр хамгаалалт хэрэгтэй шалтгаан:	Монгол мөнххаргана уствал юу болох вэ:
<ul style="list-style-type: none"> • Ховор, мөстлөгийн үеийн үлдэц ургамал • Маш удаан нөхөн сэргэдэг • Хүний нөлөөнд амархан сүүрдэг • Популяци тасрахад буцааж сэргээх бараг боломжгүй • Экосистемийн чухал индикатор 	<ul style="list-style-type: none"> • хөрсний тогтвортой байдал суларна • цөлжилт хурдасна • бэлчээрийн чанар буурна • бичил амьдрах орчин устана • биологийн олон янз байдал багасна • нөхөгдөхгүй генетикийн алдагдал үүснэ

Зам барилгын бүтээн байгуулалтын үйл ажиллагаагаар тус ургамал зүйлийн хувьд бүрэн устаж үгүй болох аюул нүүрлэхгүй бөгөөд тархац нутаг нь таллан хуваагдах нөхцөл үүснэ. Тиймээс хамгааллын арга хэмжээг хамгийн чухал хэсгийг хамгаалахад чиглүүлнэ. Үүний тулд:


- Замын бүтээн байгуулалтын мөнххарганатай хэсэгт үйл ажиллагааны нөлөөллийн зурвасыг хумьж хамгийн бага байхаар тохируулна. Ялангуяа хамгийн нягт популяцитай хэсэгт 50-100 м орон зайд техникийн ажил явуулахаар тооцож микро хамгаалалтын зурвас үүсгэнэ.
- Мөн хамгийн нягт популяцитай хэсэгт кемп байршуулахгүй, карьер ашиглахгүйгээр зам барилгын үйл ажиллагааг явуулна.
- Мөн хамгийн нягт популяцитай хэсэгт таарсан малын гарцыг хааж байршил шилжүүлнэ. Ийм нэгт популяцитай хэсэгт зөвхөн ус нэвтрүүлэх хоолойг л хийх ба замын даланг хэт өндөрлөхгүй, амралтын болон түр зогсоол хийгүй, төлөвлөлтөд тусгасан байвал байршил шилжүүлнэ.
- Ус зайлуулах сувгийг урсацыг ургамлын бүс рүү чиглүүлэхгүй байхад анхаарна.
- Ургамлыг зөөхгүй аль болох байгаа газар нь хамгаалах бодлого барих ба нягт популяцитай хэсгийг бүхэлд нь хашаалан хамгаалах, тухайн орчинд техникийн хөдөлгөөнийг хязгаарлах бодлого баримтална.
- Зам барилгын бүтээн байгуулалтын үеийн нөлөөллийн мониторинг хийж, урьдчилан харж чадаагүй ч хэрэгжүүлэх шаардлагатай хамгааллын арга хэмжээг тухай бүр шинээр илрүүлэн хэрэгжүүлж ажиллана.
- Трассын нөлөөлөлд өртөх ургамлын амьдрах чадварыг тодорхойлсноор аль болох залуу бутыг буюу нийт ургамлын 30 хүртэл хувийг шилжүүлэн суулгаж, амьдрах хувийг судалж мониторинг хийнэ.

Амьдрах орчны нөхцөл. Төсөл хэрэгжих газар нутаг нь Монгол орны амьтны аймгийн газарзүйн мужлалаар Алтайн Өвөр говийн тойрогт хамаарах ба хялгана-хазаар өвс-алаг өвст, монгол өвс-баглуурт, агь-элдэв өвст, бүйлс болон бусад сөөг, сөөгөнцөрт бэлчээрт идээшин нутагладаг аргаль хонь, янгир ямаа, шивэр алагдаага, хул чичүүл, цагаан зээр, хадны тагтаа, адууч чогчоохой, цоохор хонин гүрвэл, могой гүрвэл зонхилсон өвсөн тэжээлтнийг дагасан саарал чоно, шар үнэг, хярс үнэг, мануул мий, шилүүс мий, тарважи бүргэд, зэрэг дархан цаазтай, ховор агнуурын амьтан ургамлын иж бүрдлийг агуулсан дундаж өндөр, бэсрэг уулс, ухаа толгодот хээрийн экосистемийн тогтолцоотой. Тиймээс төслийн автотозам дээр “Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц” MNS 6515:2015 стандартын хэрэгжилтийг хангах шаардлагатай бөгөөд төслийн ТЭЗҮ-д энэ шаардлагыг хангахтай холбоотой төлөвлөлт хийгдээгүй тул БОМТ-нд тусгаж байгаа юм.

Гарцын байршил. Манай улсад автозамын төсөл дээр “Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц” MNS 6515:2015 стандартын

Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Баруун нарангийн чиглэлийн 32 км автозамын төгсгөлөөс “Цагаан дэл уул” хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын автозамын төслийн байгаль орчны менежментийн 2026 оны төлөвлөгөө

гарц хийгдсэн туршлага байхгүй бөгөөд энэхүү төсөлд трассын ПК112.000, ПК160.000, ПК219+500, ПК239.000 байршлууд дээр төлөвлөсөн.



Зураг 15. Төлөвлөж буй трасс дээр байгуулах зэрлэг амьтны гарцын байршлууд

Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Баруун нарангийн чиглэлийн 32 км автозамын төгсгөлөөс “Цагаан дэл уул” хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын автозамын төслийн байгаль орчны менежментийн 2026 оны төлөвлөгөө

Хүснэгт 3. Биологийн олон янз байдлыг хамгаалах төлөвлөгөө

№	Сөрөг нөлөө	Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ховрын статустай Монгол мөнххаргана бүхий экосистемийн дундуур трасс өнгөрнө	Хамгийн чухал хэсгийг хамгаална.	Нягт популяцын байршил	байршил	4	Аймаг, сумдын захиргаатай байгуулсан нийгмийн хариуцлагын ажил, бэлчээр хамгаалах зардлаас санхүүжүүлнэ.			Хүрмэн сумын ЗД-ын санал, Аймгийн БО-ны газрын шаардлага
2	Зэрлэг амьтдын тархац нутгийг таллан хуваах	Зэрлэг амьтдад зориулсан гарц хийх	ПК112.000, ПК160.000, ПК219+500, ПК239.000	Бүхэл	4	10,050,000.00	40,200,000.00	2026-2027	“Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц” MNS 6515:2015 Хог хаягдлын тухай хууль
		Хууль бус агнуураас болгоомжлох	Бүтээн байгуулалтын хугацаанд	Бүхэл	Оператор компаниудын гэрээнд тусгаж хэрэгжүүлнэ.			2026-2028	
3	Бүтээн байгуулалтын үеийн амьтдад үзүүлэх сөрөг нөлөө	Зэрлэг амьтад нүхэнд унаж эрсдэхээс хамгаалах	Зураг төслийн төлөвлөлтөөр	Карьерын орчинд	Үйл ажиллагааны зардалд туссан			2026-2028/	
		Хог хаягдлын хашилт хамгаалалт хий		Кемпийн орчинд				2026-2028/	
Бүтээн байгуулалтын дараах орчны тохижилт, нөхөн сэргээлт хийх ажлын зардал						40,200,000.00			

4.2.3 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө

Төлөвлөж буй замын трассыг тогтоохдоо орон нутгийн малчин айлын өвөлжөө, хаваржаа зэрэг байгууламжийг дайран гарахгүй байхаар тогтоосон тул нүүлгэн шилжүүлэлт, газар чөлөөлөлтийн асуудал үүсэхгүй болно.

БОННУ-ний хүрээнд хийгдсэн хээрийн судалгаа ба Өмнөговь аймгийн Газрын Харилцаа, Барилга, Хот байгуулалтын газраас хийгдсэн судалгаагаар замын трассаас 2км хүртэлх зайд нийт 24 айл өрх, 5км хүртэлх зайд 23 айл өрх, 10км зайд нийт 31 айл өрх оршин суудаг болох нь тогтоогдсон ба эдгээр айл өрхүүдтэй нэг бүрчлэн уулзалт хийж, зөвлөлдсөний үндсэн дээр зам барилгын ажлын хугацаанд үзүүлэх тоосжилт, дуу чимээний нөлөөллийн нөхөн төлбөр олгохоор харилцан тохиролцож, уг тохиролцоог нийгмийн хариуцлагын гэрээгээр хийж тайлагнаж байхаар заасан байна.

Замын трассаас 10 хүртэлх километр зайд орших нийт 78 айл өрхийг нөлөөлөлд өртөж болзошгүй гэж тодорхойлж байгаа бөгөөд малчин өрхүүдэд амьжиргааны дэмлэг бүхий бодлогын түвшний нийгмийн хариуцлагын гэрээг орон нутагтай ярилцаж шинэчлэх талаар төсөл хэрэгжүүлэгч мэдээлж байна.

Төсөл хэрэгжүүлэгч өмнө Аймагт болон төслийн харьяа сумдын захиргаатай нийгмийн хариуцлагын 19 зүйл бүхий гэрээ 3 талт гэрээ байгуулан ажиллаж ирсэн бөгөөд орон нутгаас тавьсан саналын дагуу уг гэрээнд өөрчлөлт оруулахаар зөвшилцөлд хүрээд байгаа юм байна.

4.2.4 Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Ажлын хамрах хүрээ. Төслийн орчны тохижилтын төлөвлөлтөд зам барилгын ажлын бүтээн байгуулалтын дараах тохижилтын ажлууд хамаарна. Үүнд:

1. Замын дагуух үйлчилгээний газрууд, хяналтын постуудын орчны тохижилт
2. Замын дагуух түр зогсоол, амрах карманы орчны тохижилт
3. Карьер ашиглалт дууссаны дараах хэлбэршүүлэн нөхөн сэргээлт
4. Үер усны эрсдэлтэй газруудын хамгааллын далан, шуудууг хийсний дараах тохижилт, нөхөн сэргээлт зэрэг ажлууд хамаарна.

2026-2027 онд хийх ажил. Зам барилгын бүтээн байгуулалтын 2026-2027 оны мөчлөгт хугацаанд орчны тохижилт, нөхөн сэргээлтийн ажил хийгдэх төлөвлөлтгүй байна. Учир нь зам барилгын бүтээн байгуулалт, ид газар шорооны ажил хийж байх тул бүтээн байгуулалтын энэ хугацаанд тохижилт, нөхөн сэргээлт хийх тухай ярих боломжгүй юм.

Харин хожмын нөхөн сэргээлтийн бэлтгэл ажил болгож трассын нөлөөлөлд өртөх 20 гаруй км туушид тааралдах Монгол мөнххарганы үрийг түүж бүтээн байгуулалтын дараах нөхөн сэргээлтэд ашиглах болно.

Монгол мөнххарганыг хамгаалах. Монгол мөнххарганыг хамгаалах асуудал нь олон улсын хэмжээнд баримталдаг биологийн төрөл зүйлийг хамгаалах бодлого, зарчимтай бүрэн уялдаатай. Монгол Улс энэхүү конвенцийн гишүүн бөгөөд:

- Ховор, устаж болзошгүй зүйлүүдийг хамгаалах
- Экосистемийг бүхэлд нь хадгалах
- In-situ (байгальд нь) болон ex-situ (хүлэмж, үрийн сан) хамгаалалтыг хослуулах гэсэн зарчмуудыг баримталдаг байх үүрэгтэй байдаг хүрээнд хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Ялангуяа Монгол мөнххаргана нь мөстлөгийн үеэс үлдсэн, ховор зүйл тул олон улсын гэрээний хамгаалалтын тэргүүлэх зорилтод шууд хамаарах тул хамгаалал нь:

- Олон улсын гэрээ
- Шинжлэх ухаанд суурилсан бодлого
- Нөлөөлөл бууруулах зарчим зэрэгтэй шууд уялдсан, зайлшгүй шаардлагатай ажлуудыг хийнэ.

Хүснэгт 24. Хамгааллын арга хэмжээний бодлого

№	Хамгааллын бодлого	Хамгааллын арга хэмжээ
1	Нөлөөллийг бууруулах	<ul style="list-style-type: none">• Түр зам, талбайг хязгаарлах• Хурд хязгаарлах, тоос дарах• Хөрсний дээд үеийг хадгалах• Барилгын ажлыг улирлын хувьд тохируулах (цэцэглэлтийн үед зогсоох)
2	Нөхөн сэргээх	<ul style="list-style-type: none">• Хөрс буцаан байрлуулах• Уугуул ургамал сэргээх• Мөнххарганы нөхөн сэргээлтийн туршилт
3	Гений санг хамгаалах	<ul style="list-style-type: none">• Ижил экосистемд хамгаалалтын талбай байгуулах• Үрийн сан бүрдүүлэх

Тиймээс Монгол мөнххарганыг хамгаалахад төлөвлөгөөний эхний бүлэгт өгүүлсэн хамгааллын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж зардлын нийгмийн хариуцлагын сагаас гаргахаар төлөвлөж байна.

4.2.5 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Археологийн хүрээлэнгээр 2019 оны 1-р улиралд хийлгэсэн судалгааны ажлын үр дүнд 25 ширхэг түүх, соёлын дурсгалыг баримтжуулсан. Үүнд булш оршуулгын дурсгал 7, чулуун байгууламж 17, Чингисийн далан зэрэг багтана. Замын трасс нь булш, чулуун дурсгалуудаас 150 метрээс дээш зайтай байх ба зам барилгын бүтээн байгуулалтад өртүүлэхгүйгээр хашиж хамгаална.

Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Баруун нарангийн чиглэлийн 32 км автозамын төгсгөлөөс “Цагаан дэл уул” хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын автозамын төслийн байгаль орчны менежментийн 2026 оны төлөвлөгөө

Хүснэгт 25. Трассын дагуух зурвас газарт бүртгэгдсэн түүхийн дурсгалт зүйлүүд

Дурсгалын дугаар	Өргөрөг	Уртраг	Дурсгалын төрөл	Харьяалал /сум/	Замаас алслагдсан байдал /м/
T-1	N:43 34 55.5	E: 105 15 04.0	Булш	Ханхонгор	Зүүн -117м
T-2	N: 43 34 53.8	E: 105 15 07.6	Булш	Ханхонгор	Зүүн- 218м
T-3	N: 43 33 07.3	E: 105 13 07.6	Булш	Ханхонгор	Баруун-120м
T-4	N: 43 28 05.9	E: 104 48 20.7	Чулуун байгууламж	Ханхонгор	Баруун- 150м
T-5	N: 43 27 39.4	E: 104 47 29.6	Чулуун байгууламж	Ханхонгор	Баруун- 200м
T-6	N: 43 27 20.7	E: 104 46 40.2	Чулуун байгууламж	Ханхонгор	Баруун-145м
T-7	N: 43 23 36.4	E: 104 37 07.3	Чулуун байгууламж	Ханхонгор	Зүүн- 105м
T-8	N: 43 23 36.9	E: 104 37 07.9	Чулуун байгууламж	Хүрмэн	Зүүн- 105м
T-9	N: 43 02 09.7	E: 104 14 06.5	Чулуун байгууламж	Хүрмэн	Зүүн- 175м
T-10	N: 43 01 31.2	E: 104 13 58.3	Чулуун байгууламж	Хүрмэн	Баруун-180м зүүн- 150м
T-11	N: 42 53 15.6	E: 104 08 54.8	Чулуун байгууламж	Хүрмэн	Зүүн- 130м
T-12	N: 42 53 48.2	E: 104 09 29.9	Чулуун байгууламж	Хүрмэн	Зүүн- 150м
T-13А	N: 42 29 30.1	E: 104 09 36.6	Чулуун байгууламж	Хүрмэн	Баруун-“№:
T-13Б	N: 42 28 51.8	E: 104 09 19.6	Чингисийн далан	Хүрмэн	
	N: 42 28 37.8	E: 104 09 00.0		Хүрмэн	
T-14	N: 42 07 34.8	E: 104 17 16.0	Булш	Хүрмэн	Баруун- 180 м
T-15	N: 43 02 48.0	E: 104 10 23.7	Булш	Хүрмэн	Зүүн- 397м
T-16	N: 43 02 42.9	E: 104 10 29.0	Булш	Хүрмэн	Зүүн- 550 м
T-17	N: 43 03 44.8	E: 104 12 15.	Чулуун байгууламж	Хүрмэн	Баруун- 55м
T-18	N: 42 29 24.5	E: 104 09 33.5	Чулуун байгууламж	Хүрмэн	Баруун- 345м
T-19	N: 42 29 11.3	E: 104 09 26.5	Булш	Хүрмэн	Баруун- 346м
T-20	N: 42 29 07.7	E: 104 09 25.1	Чулуун байгууламж	Хүрмэн	Баруун- 290м
T-21	N: 42 29 08.2	E: 104 09 25.8	Чулуун байгууламж	Хүрмэн	Баруун- 288м
T-22	N: 42 29 02.2	E: 104 09 21.6	Чулуун байгууламж	Хүрмэн	Баруун- 205м
T-23	N: 42 28 58.4	E: 104 09 18.1	Чулуун байгууламж	Хүрмэн	Баруун- 165м
T-24	N: 42 07 50.5	E: 104 17 08.7	Чулуун байгууламж	Хүрмэн	Баруун- 65м

Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Баруун нарангийн чиглэлийн 32 км автозамын төгсгөлөөс “Цагаан дэл уул” хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын автозамын төслийн байгаль орчны менежментийн 2026 оны төлөвлөгөө

Хүснэгт 26. Түүхийн дурсгалт зүйлүүдийг хамгаалах арга хэмжээний зардлууд

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Археологийн судалгаагаар олдсон 7 булш, 1 далан, 16 чулуун байгууламж	хашиж хамгаалах, гэмдэг-самбар тавих	Археологийн зүйлүүдийн байршлаар	24	520000	12,480,000.00	2026 онд	Түүх соёлын өвийг хамгаалах тухай хууль, Төслийн БОННУ, түүний зөвлөмж
2	Чингэсийн далан	Трасс хөндлөн гарах хэсэгт малтлага хийх	Трасс, далан 2 огтолцох хэсэгт	1	15000000	4,000,000.00	2026 онд	
Түүх, соёлын биет өврийг хамгаалах арга хэмжээний зардал							16,480,000.00	

Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Баруун нарангийн чиглэлийн 32 км автозамын төгсгөлөөс “Цагаан дэл уул” хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын автозамын төслийн байгаль орчны менежментийн 2026 оны төлөвлөгөө

4.2.6 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Осол эрсдэлээс хамгаалах арга хэмжээ нь бүтээн байгуулалтын үед оператор компаниудад тавих шаардлагаар, зам ашиглалтын үед замын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаагаар хэрэгжинэ.

Хүснэгт 27. Галын буланд заавал байршуулах иж бүрдлүүдийн хэсгүүд

№	Хамгаалах хэрэгслийн төрлүүд	Зураг
1	<p>Галын хорны төрөл</p> <ul style="list-style-type: none"> Усан унтраагуур бүхий галын хор Нунтаг унтраагуур бүхий галын хор Хөөсөн унтраагуур бүхий галын хор Хийн унтраагуур бүхий галын хор 	
2	<p>Галын саравчид байх иж бүрдэлд байх зүйлүүд:</p> <ul style="list-style-type: none"> унтраах бодис; суурилуулах; тоног төхөөрөмж; анхдагч сан; хөдөлгөөнт хэрэгсэл; галын саравчийг зассан арга. 	
3	<p>Мөн автозам ашиглалтын үеийн хөдөлгөөний дараалал заасан тэмдэг тэмдэглэгээг байршуулж хөдөлгөөнд оролцогчдыг дүрмийн дагуу хөдлөх нөхцөлийг бүрдүүлж осол, эрсдэлээс сэргийлнэ.</p>	
